

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН 2025

Агуулга

1. Удиртгал

2

Группийн танилцуулга
Түүхэн замнал
Үнэт зүйл, Эрхэм зорилго
Гүйцэтгэх захирлын зурвас
Удирдлагын багийн бүтэц
Бизнесийн салбарууд
Бизнесийн салбаруудын түвшинд гарсан ахиц, зорилтууд
Монгол Улсын хөгжилд оруулсан хувь нэмэр
НҮБ-н Тогтвортой хөгжлийн зорилтууд (SDG)

2. Байгаль орчин

13

Уур амьсгал, эрчим хүч
Биологийн олон янз байдал, хог хаягдал

3. Нийгэм

26

Хүний нөөц, ХЭМАБ, олон талт байдал
Орон нутгийн оролцоо, хүний эрх

4. Засаглал

43

Компанийн засаглал
Комплэйнс, Эрсдлийн удирдлага

5. Хавсралт

51

Байгаль орчин, нийгэм, засаглалын стратегийн чиглэл
GRI индекс

Группийн танилцуулга

“Бодь Интернэшнл” ХХК нь Монгол Улсын ардчиллын шилжилтийн түүхэн цаг үед байгуулагдсан хувийн хэвшлийн анхдагчдын нэг бөгөөд өнөөдөр үндэсний хэмжээний тэргүүлэгч “Бодь Групп” болон өргөжин хөгжсөн байна.

Өнгөрсөн гурван арван жилийн хугацаанд бид барилга, дэд бүтэц, банк санхүү, хэвлэл мэдээлэл, аялал жуулчлал, хүнс, хөдөө аж ахуй зэрэг олон салбарт хөрөнгө оруулж, олон улсын стандарт, дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлснээр салбар бүрд үнэ цэн бүтээж, шинэ жишгийг тогтоосоор ирлээ. Бид зөвхөн мега бүтээн байгуулалтад хөрөнгө оруулснаар зогсохгүй, төслийн менежментийн олон улсын туршлагыг

Монголд нутагшуулж, үндэсний инженер, мэргэжилтнүүдийн үр чадварыг тасралтгүй хөгжүүлж байна. Энэ нь цаашдын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулж буй шинэ үеийн чадварлаг боловсон хүчнийг төлөвшүүлэх үндэс болсон юм.

Сүүлийн жилүүдэд “Бодь Групп”-ийн компаниуд Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий төмөр зам, эрчим хүч, уул уурхай, барилга, дэд бүтцийн томоохон төслүүдийг амжилттай хэрэгжүүлж байна. Ингэснээр бид зөвхөн салбар бүрийн хөгжилд төдийгүй улсын эдийн засгийн бүтцэд бодит жин дарж байна.



Түүхэн замнал



1993



“Бодь Интернэшнл” ХХК 1993 оны 07 дугаар сарын 06-ны өдөр үүсгэн байгуулагдав.

1995



Хувийн арилжааны “Голомт банк”, анхны лизингийн үйлчилгээний “Монгол Лизинг” компаниудыг байгуулав.

1997



Барилгын төсөл хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах “Бодь Пропертиз” ХХК-ийг байгуулав.

1999



Олон улсын төлбөрийн картын системийг /Mastercard/ Монгол Улсад анхлан нэвтрүүлэв.

2001



Барилгын салбарын үйл ажиллагаагаа өргөжүүлж, Монгол-Оросын хамтарсан “Инкон” ХХК-д хөрөнгө оруулалт хийв.

2003



Хамгийн орчин үеийн дизайн шийдэл бүхий “Бодь цамхаг” ухаалаг оффисын барилгыг ашиглалтад оруулав.

2006



“Голомт хотхон” орон сууц болон үйлчилгээний цогцолборыг бүрэн ашиглалтад оруулав.

2009



Улаанбаатар хотын иргэдийг эрүүл, чанартай хүнсний ногоогоор хангах зорилготой “Грийн сити гарден” ХХК-ийг байгуулав.

2025



“Бөөрөлжүүт цахилгаан станц”-ын хоёр дахь блокыг ашиглалтад оруулж, нийт 300 МВт хүчин чадлаар эрчим хүч нийлүүлж эхэллээ.

2024



- “Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв” төслийн бүтээн байгуулалтыг дуусгаж, ашиглалтад хүлээлгэн өгөв.
- “Бөөрөлжүүт цахилгаан станц”-ын эхний 150 МВт блокыг ашиглалтад оруулж, эрчим хүчний нэгдсэн системд холбов.

2023



Гашуунсүхайд боомт дахь “Шилжүүлэн ачих терминал”-ыг барьж байгуулав.

2022



Монголын анхны нэгдүгээр зэрэглэлийн “Тавантолгой-Гашуунсүхайд” чиглэлийн төмөр замыг барьж байгуулан ашиглалтад хүлээлгэн өгөв.

2019



“Бөөрөлжүүт цахилгаан станц”-ын нарийвчилсан судалгааны ажлуудыг 9 жил хийж, станцын зураг төслийг боловсруулав.

2015



Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт “Red Rock Resort” төслийг хэрэгжүүлж, үйл ажиллагааг нь эхлүүлэв.

2014



Банк санхүү, даатгал, үнэт цаас, хөрөнгө оруулалт, санхүүгийн нэгдэл “Голомт Файнэншл Групп” компанийг байгуулав.

2011



“Цэцэнс Майнинг энд Энерги” ХХК-д хөрөнгө оруулалт хийж, уул уурхай, эрчим хүчний салбарт үйл ажиллагаа эхлүүлэх суурийг тавив.



Үнэт зүйл

Бидний хөгжил, өсөлт, ирээдүйг чиглүүлдэг гурван үнэт зүйл.



БОДЬ СЭТГЭЛГЭЭ

Хүн ба байгальдаа ээлтэй, хамтын хөгжил дэвшилд оюун ухаан, сэтгэл зүрхээ зориулдаг, ёс зүйг дээдлэгч байна.



БОДИТ МАНЛАЙЛАЛ

Зарчмаа тэргүүнд эрэмбэлэн, сорилт бүр дэх боломжийг соргог тусгаж, үйл хэргээрээ үлгэрлэн манлайлагч байна.



ЦОГЦЛООН БҮТЭЭГЧ

Инновац, сайн туршлагыг шингээсэн ухаалаг шийдлээр өнөөдрийг ирээдүйтэй холбож, зорьсноо хариуцлагатайгаар цогцлоон бүтээгч байна.

Эрхэм зорилго

Монгол улсын хөгжлийн голлох салбаруудад олон улсын жишигт нийцсэн, чанар, өндөр бүтээмжтэй, нийгмийн хариуцлагатай, ёс зүйтэй бизнесийг төлөвшүүлсэн үлгэр жишээ сайн засаглалтай компани байхад оршино.



Б. ДОЛГОРМАА

Гүйцэтгэх захирал, Бодь Интернэшнл ХХК

Гүйцэтгэх захирлын зурвас

Монгол Улсын эдийн засгийн хөгжил, бүтээн байгуулалт, бизнесийн орчны өсөлттэй зэрэгцэн тогтвортой хөгжил, байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ буюу ESG) зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх нь байгууллагуудын нэн чухал зорилт болоод байна.

Бодь Групп нь 30 гаруй жилийн хугацаанд олон салбарт үйл ажиллагаагаа тэлэхдээ хариуцлагатай засаглал, ил тод байдал, ёс зүйтэй бизнесийн зарчмыг эрхэмлэн, тогтвортой хөгжлийг урт хугацааны үнэ цэнийг бүтээх үндсэн суурь гэж үзэн ажиллаж ирлээ.

2025 онд бид БОНЗ-ын удирдлага, тайлагналын тогтолцоогоо шинэ шатанд гаргаж, хэмжигдэхүйц зорилт болон олон улсын сайн туршлагад нийцсэн бодлого, менежментийн аргачлалуудыг үе шаттайгаар нэвтрүүлж, ISO 9001:2015 стандартын хэрэгжилтээ баталгаажуулснаар байгууллагын засаглал болон чанарын удирдлагын тогтолцоогоо бэхжүүлэн ажиллалаа.

Байгаль орчны хариуцлагын хүрээнд бид "100 Зуун Мод" төслийн хүрээнд 10,945 мод тарьж, жил бүр дунджаар 1,300 тонн хүчилтөрөгч ялгаруулан, 230 тонн нүүрсхүчлийн хий (CO₂) шингээх үр

нөлөөг бий болгож байна. Үүнтэй зэрэгцэн группийн охин компаниуд тогтвортой хөгжил, байгаль орчны хариуцлагын чиглэлээр бодит үр дүн бүхий ажлуудыг хэрэгжүүллээ.

"Цэцэнс Майнинг Энд Энержи" компани нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг 96 хувьтай хангаж, 2.2 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж, 13,000 мод тарьж, 5 төрлийн шувуу нутагшсан 5 га хиймэл нуурыг байгуулан биологийн олон янз байдлыг дэмжив.

"Рэд Рок Холдинг" компани Хөвсгөл нуурын зүүн эргийн ойн бүсэд 104 м³ хэмжээтэй ойн цэвэрлэгээний ажлыг хэрэгжүүлж, ойн экосистемийн эрүүл байдлыг сэргээхэд хувь нэмэр орууллаа. Харин "Үндэсний Соёл Амралтын Хүрээлэн" нь Улаанбаатар хотын төв дэх 5.8 га талбай бүхий нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, ил задгай орон зайг хадгалан хамгаалж, хотын экологийн тэнцвэрт байдалд бодит хувь нэмэр үзүүлэн ажиллаж байна.


Мөн бид үйл ажиллагааны үр ашгаа нэмэгдүүлэхийн зэрэгцээ байгаль орчны нөлөөлөө бууруулах чиглэлд бодит ахиц гаргаж

байна. "Бодь Интернэшнл" компанийн түлшний хэрэглээг 72 хувиар бууруулж, "Цэцэнс Майнинг Энд Энержи"-ийн хаягдлын 98 хувийг дахин боловсруулан, "Рэд Рок Ресорт" нь урт хугацаанд CO₂ нөхөн шингээх эко орчныг бүрдүүлсэн нь тогтвортой өсөлтийн зорилтын маань бодит илэрхийлэл болж байна.

Цаашид Бодь Групп нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдсан стратегиа улам бэхжүүлж, БОНЗ-ын гүйцэтгэлээ олон улсын жишигт нийцүүлэн үнэлүүлэх, хүлэмжийн хийн тооллогоо баталгаажуулах, тогтвортой санхүүжилтийн хэрэгслүүдийг үе шаттайгаар нэвтрүүлэх зорилт тавин ажиллаж байна. Мөн 2033 он гэхэд МХБ-ын БОНЗ удирдамжийн 16 шалгуурыг бүрэн хангаж, Монголын тогтвортой бизнесийн жишиг байгууллага болохыг зорьж байна.

Бид бизнесийн өсөлт, нийгмийн үнэ цэнэ, байгаль орчны хариуцлага нэгдсэн цагт жинхэнэ тогтвортой хөгжил бий болно гэдэгт итгэдэг. Энэхүү зорилгын төлөө хамтран ажиллаж буй нийт харилцагч, түнш байгууллага, хөрөнгө оруулагчид болон хамт олондоо талархал илэрхийлье.


Удирдлагын багийн бүтэц



Б.ЭРДЭНЭБАЯР
"Бодь Интернэшнл" ХХК-ийн
Төсөл хариуцсан захирал




С.МӨНХБААТАР
"Бодь Интернэшнл" ХХК-ийн
Бизнес хариуцсан захирал



Б.ЧИМЭГСҮРЭН
"Бодь Интернэшнл" ХХК-ийн
Санхүү хариуцсан захирал



Б.МӨНХБАЯР
"Инкон" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



Д.МӨНХТӨР
"Цэцэнс Майнинг энд Энержи" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



П.БАТХҮҮ
"Рэд Рок Холдинг" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



Н.МЭНДБАЯР
"Үндэсний Соёл Амралтын Хүрээлэн" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



Э.НЯМДАВАА
"Бодь Рэйл" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал




Б.ТЭГШБАЯР
"Бодь Пропертиз" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

Бизнесийн салбарууд

Бид салбар бүрт инноваци, бүтээмж, хариуцлагыг хослуулж, тогтвортой өсөлт ба бизнесийн манлайллыг бататган харуулж байна.




"Бодь Интернэшнл" ХХК нь 1993 онд үндэсний хөрөнгө оруулагчдын санаачлагаар үүсгэн байгуулагдсан бөгөөд барилга, дэд бүтэц, уул уурхай, банк санхүү, хэвлэл мэдээлэл, хүнс, хөдөө аж ахуй зэрэг салбаруудад тэргүүлэгч бизнесүүдийн нэгдэл болох Бодь группийн толгой компани юм.



"Үндэсний Соёл Амралтын Хүрээлэн" компани нь 2009 онд үүсгэн байгуулагдаж, шинэ өнгө төрхтэйгөөр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Одоогоор 20 гаруй төрлийн аттракцион тоглоом, хоол үйлчилгээ, автомат, хөгжөөнт энтертайнмент төвүүдтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.



"Рэд Рок Холдинг" компани 2015 оноос эхлэн Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт байрлах, иж бүрэн инженерийн шийдэл бүхий "Red Rock Resort" сургалт, амралтын цогцолборын үйл ажиллагааг эрхэлж байна.



2011 онд байгуулагдсан "Цэцэнс Майнинг Энд Энержи" компани нь Монгол улсын эдийн засгийн өсөлтөд жинтэй хувь нэмэр оруулахуйц, иргэн айл өрх бүрт хүртээмжтэй их бүтээн байгуулалтыг Төв аймаг, Бөөрөлжүүгийн талд өрнүүлж байна.



"Бодь Рэйл" компани нь төмөр замын төслүүдийг үр ашигтай зохион байгуулах, шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх, өсөн нэмэгдэж буй тээврийн хэрэгцээг хангах, уул уурхайн бүтээгдэхүүний экспортод хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна.




1992 онд байгуулагдсан "Инкон" компани нь барилга угсралт, төмөр замын дэд болон дээд бүтэц, инженерийн барилга байгууламжийн угсралт, барилгын материал, хийц үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг. Өнгөрсөн хугацаанд 40 гаруй томоохон бүтээн байгуулалтыг гүйцэтгэсэн.



1997 онд байгуулагдсан "Бодь Пропертиз" ХХК нь үл хөдлөх хөрөнгө, барилга угсралтын ажлын төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилтийг иж бүрэн гүйцэтгэгч төслийн байгууллага юм.

Бизнесийн салбаруудын түвшинд гарсан ахиц, зорилтууд

ЦЭЦЭНС МАЙНИНГ ЭНД ЭНЕРЖИ ХХК - Уул уурхай, эрчим хүч



CO₂ ЯЛГАРАЛ

1.49 сая тн

Хүлэмжийн хийг бууруулах

ТҮЛШНИЙ ХЭРЭГЛЭЭ

4.64 сая л


Түлшний үр ашгийг сайжруулах

КАРБОН ОФСЕТ

240 тн

Ойжуулалтыг нэмэгдүүлэх

БОДЬ РЭЙЛ ХХК - Төмөр зам, тээвэр



CO₂ ЯЛГАРАЛ

11,072 тн

Тээврийн ухаалаг системээр ялгарлыг бууруулах

ДИЗЕЛИЙН ХЭРЭГЛЭЭ

4.51 сая л


Дизелийн хэрэглээг үе шаттай оновчлох

ХЭМАБ СУРГАЛТ

26 цаг/хүн

ХЭМАБ соёлыг тасралтгүй бэхжүүлэх

ИНКОН ХХК - Барилга угсралт



БАРИЛГЫН ХОГ ДАХИН АШИГЛАЛТ

80%

Дахин боловсруулалтыг тогтвортой хадгалах

VIM/PROCORE НЭВТРҮҮЛЭЛТ

100%


Дижитал шилжилтийг дэмжих

ЭМЭГТЭЙ ИНЖЕНЕРҮҮД

28%

Олон талт байдлыг дэмжих

ҮНДЭСНИЙ СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН ХХК - Энтертайнмент үйлчилгээ



ЦАХИЛГААН ХЭРЭГЛЭЭ

1.44 сая кВт.ц

Эрчим хүчний хэмнэлтийн Сэргээгдэх шийдэл нэвтрүүлэх

НОГООН БАЙГУУЛАМЖ

5.8 га

Ногоон бүсийг хадгалж, тэлэх

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТОО

782 мянга+

Үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах

БОДЬ ПРОПЕРТИЙЗ ХХК - Барилга угсралт



ДУЛААН АЛДАГДАЛЫН БУУРАЛТ

18%

Эрчим хүчний хэмнэлт

CO₂ ЯЛГАРАЛ / ЖИЛ (SCOPE 1+2)

120 тн

CO₂ ялгарал бууруулах

ХЭМАБ СУРГАЛТ

18 цаг/хүн

ХЭМАБ соёлыг тасралтгүй бэхжүүлэх



РЭД РОК ХОЛДИНГ ХХК - Аялал жуулчлал

CO₂ ЯЛГАРАЛ

3,837 тн

Нүүрстөрөгчийн саармаг баазыг хадгалах

КАРБОН ОФСЕТ

4.054 тн

Ойн цэвэрлэгээ, нөхөн сэргээлтийг үргэлжлүүлэх

ЭМЭГТЭЙ АЖИЛТАН

63.2%

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Монгол Улсад оруулсан бодит хувь нэмэр

Сүүлийн дөрвөн жилд Бодь Группийн охин болон хөрөнгө оруулалттай компаниуд улсын төсөвт нийт 2 их наяд төгрөгийн татвар, шимтгэл төвлөрүүлжээ. Энэхүү үзүүлэлт нь Монголын хувийн хэвшлийн тэргүүлэх төлөөллийн хувьд Бодь Группийн эдийн засгийн бодит хувь нэмэр, хариуцлагатай манлайллыг бататган харуулж байна. Мөн энэ хугацаанд гадаад, дотоодын 11,900 гаруй бизнес эрхлэгчтэй хамтран ажиллаж, 1.2 их наяд төгрөгийн бараа, ажил үйлчилгээг дотоодын компани, хувь

хүнээс худалдан авсан байна. Энэ нь үндэсний аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадвар, өсөлт хөгжилд бодит дэмжлэг үзүүлж Бодь Группийн "хамтын өсөлт" зарчмыг бодитоор хэрэгжүүлсэн томоохон жишээ юм. Өнөөдөр "Бодь Групп" нь эдийн засгийн голлох салбаруудад чухал байр суурь эзэлж, олон улсын түншлэлээр хамтдаа өсөж дэвжихийн зэрэгцээ Монгол Улсын тогтвортой хөгжилд бодит манлайлал үзүүлсээр байна.

ОНЦЛОХ
ҮЗҮҮЛЭЛТ

2.0 их наяд ₮

Сүүлийн 4 жилд улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, шимтгэл

1,190+

Аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч - Дотоод, гадаад хамтын ажиллагаа

10,000+

Шууд болон шууд бус ажлын байр

437,396 м²

Барилгын нийт гүйцэтгэсэн талбай

1.2 их наяд ₮

Дотоодын компаниуд болон хувь хүмүүсээс хийсэн худалдан авалт

755 сая ₮

Нийгмийн хариуцлагын хүрээнд оруулсан хөрөнгө оруулалт

1,200+

Орон нутгийн жижиг дунд нийлүүлэгчид

1 тэрбум кВт.ц

2025 онд үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт Монгол Улсын хүрээнд

Тогтвортой Хөгжлийн Зорилгууд (ТХЗ) нь ядуурлыг арилгах, эх дэлхийгээ хамгаалах, хүн төрөлхтөн амар амгалан, хөгжил цэцэглэлтийн үр шимийг хүртэхэд чиглэсэн дэлхийн хэмжээний зорилт юм. Тогтвортой хөгжлийн зорилтууд нь нийгэм, эдийн засаг, байгаль орчны харилцан тэнцвэртэй байдлыг хангахад чиглэсэн хоорондоо нягт холбоотой 17 зорилгоос бүрддэг бөгөөд нэг салбар дахь үйл ажиллагаа нь бусад салбаруудад шууд нөлөөлдөг гэсэн үг юм. Монгол Улс өөрийн “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг Тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулсан бөгөөд хувийн хэвшил энэхүү замналд хамтран оролцогч гол түнш юм.



Бодь Группийн үйл ажиллагаа НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд

Бодь Группийн үйл ажиллагаа болон тэргүүлэх ач холбогдол бүхий төслүүдийг НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн 17 зорилгоос дараах есөн зорилготой нийцэн ажиллаж байна. Бид UNDP Mongolia, Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоотой группийн түвшинд идэвхтэй хамтран ажиллана.

Эх сурвалж: НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP Mongolia) — undp.org/mn/mongolia/sustainable-development-goals.

7 AFFORDABLE AND CLEAN ENERGY 

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ НЭВТРҮҮЛЭХ

Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК
2030 он гэхэд сэргээгдэх эх үүсвэрийн эзлэх хувь $\geq 20\%$.

8 DECENT WORK AND ECONOMIC GROWTH 

ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

- 10,000+ шууд ба шууд бус ажлын байр
- Ажилтны эрх, нийгмийн хамгаалал
- ХЭМАБ-ын стандартыг 100% мөрдөнө.

9 INDUSTRY, INNOVATION AND INFRASTRUCTURE 

ИННОВАЦИ БОЛОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Инкон ХХК, Бодь Пропертиз ХХК
Олон улсын стандартад нийцсэн дэд бүтэц, BIM, IoT, ухаалаг оффисын шийдлүүд

11 SUSTAINABLE CITY AND COMMUNITIES 

ТОГТВОРТОЙ ХОТ, ИРГЭДИЙН АМЬДРАЛ

Үндэсний соёл амралтын хүрээлэн ХХК
Улаанбаатар хотын төв хэсэгт 5.8 га ногоон байгууламжтай.

12 RESPONSIBLE CONSUMPTION AND PRODUCTION 

ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭ БА ҮЙЛДВЭРЛЭЛ

Хариуцлагатай худалдан авалт
1,200 нийлүүлэгчээс 73% нь дотоодын, ногоон гэрчилгээтэй нийлүүлэлттэй.

13 CLIMATE ACTION 

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭСРЭГ АРГА ХЭМЖЭЭ

100 Зуун Мод
10,945 мод, жилд 230 тонн CO₂ шингээнэ.

15 LIFE ON LAND 

ГАЗРЫН ЭКОСИСТЕМИЙГ ХАМГААЛАХ

Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК
2.2 га нөхөн сэргээлт, 5 га хиймэл нуур

16 PEACE, JUSTICE AND STRONG INSTITUTIONS 

ЭНХ ТАЙВАН, ЗАСАГЛАЛ

- Сайн засаглал 2.0
25 бодлого шинэчилсэн
- Bodi Voice


17 PARTNERSHIPS FOR THE GOALS 

ТҮНШЛЭЛ

ТОС холбоо, БОНЗ-н зөвлөх байгууллагуудын түншлэл.

Байгаль орчин

Байгаль орчноо хамгаалж, үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулан, ирээдүй хойч үедээ үнэ цэн бүтээхийг эрхэмлэнэ.



Байгаль орчны менежмент ба ногоон эдийн засаг

Группийн Цэцэнс Майнинг Энд Энержи компани нь иж бүрэн байгаль орчны менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн. Рэд Рок Холдинг компани нь Грийн Сити Гарден компаниараа дамжуулан хаалттай хүнсний тойрог бүрдүүлж, байгалийн нөөцийн хэрэглээг бууруулж байна.

Байгаль орчин – Нөхөн сэргээлт ба Усны менежмент

Бодь Групп нь ногоон хөгжлийн бодлогын хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төсөл болон бусад төслүүдийн хүрээнд өмнө нь эвдэрсэн, бохирдсон байсан газруудыг иж бүрэн нөхөн сэргээсэн.

Нөхөн сэргээлт

120ш

Нэгж талбарт (ТТГС, ШАТ, ТТ-3Б төслүүд) техникийн нөхөн сэргээлт хийж, орон нутагт хүлээлгэн өгсөн.



13,000

бут сөөг тарьсан.

20+ га талбайд



5га

- Хиймэл нуур
- 5 шувуу нутагшуулсан

Биологийн хамгаалал



CO₂ялгаралт

бууруулсан.

CO₂ хэмжилт 2025

Жавхлант нуур төсөл

Бөөрөлжүүт уурхайн шүүрлийн усыг ашиглан байгуулсан энэхүү нуур нь бүс нутагт усны шинэ экосистемийг бүрдүүлж, өвөгт тогоруу, гангар хун зэрэг ховор шувуудын нутагших таатай орчин болсон.

Хог хаягдлын менежмент



1,905.9тн

Энгийн хог хаягдал



16.1тн

Аюултай хог хаягдал

2,349.5тн

Барилгын хог хаягдал

Ногоон байгууламж



35.8га

ТНАЛТ, ШАТ, ТТ-3Б төслийн хүрээнд нийт 35.8 га талбайг MNS 5914:2008 стандартын дагуу иж бүрэн нөхөн сэргээв.

Хог хаягдал



4,271.5тн

энгийн болон барилгын хог хаягдлыг ангилан төвлөрүүлсэн.

Аюултай хог хаягдал



16.1тн

аюултай хаягдлыг дахин боловсруулалтад шилжүүлсэн.



967ажилтан

Байгаль орчны чиглэлээр нийт **33 туслан** гүйцэтгэгчийн **967 ажилтанд** сургалт орсон.

 **BODI INTERNATIONAL**

“Бодь Интернэшнл” ХХК нь ногоон хөгжлийн бодлогодоо тулгуурлан хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хадгалах, үр өгөөжийг ирээдүй хойч үедээ урт хугацаанд хүртэх боломжоор хангах нөхцөлийг бүрдүүлсэн компани болох зорилт тавин ажиллаж байна. Энэ хүрээнд 2025 оны байдлаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн. Монгол улсын “Усны тухай хууль”-ийн 28-р зүйлийн 28.6, 28.8 дахь заалт, 29-р зүйл, “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль”-ийн 21-р зүйлийн 21.1.20 дахь заалт, Засгийн газрын 2011 оны “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээ тогтоох тухай” 199-р тогтоол, Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 101-р тогтоол, “Монгол Ус” ТӨҮГ-ын ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн төслийн усан хангамжид нийт 38 худгийн зөвшөөрөл, дүгнэлт, гэрээ байгуулснаас 33 худгийг ашиглан, 19 худгийг “Усны тухай хууль”-ийн 22-р зүйлийн 22.17-д заасны дагуу орон нутагт, 11 худгийг төслийн захиалагч талд тус тус хүлээлгэн өгсөн.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын трасс дээр болон нүүрс тээвэрлэлтийн хатуу хучилттай авто зам дагуу иргэд болон нүүрс тээврийн компаниуд газар ашиглах зөвшөөрөлгүй /хууль бус/ үйл ажиллагаа явуулж байсныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Өмнөговь аймгийн засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж, газар чөлөөлөх ажилд нийт 750 га газрыг бүрэн чөлөөлж, экологи эдийн засгийн өндөр хохирол учирсан, газрын хэвлий ихээр эвдсэн байсныг таслан зогсоож, хүрээлэн буй орчинд үүссэн хаягдал дүгуй 3000 ш, бусад 2512.8 тн хур хог хаягдлыг цэвэрлэн булшлах цогц арга хэмжээг авч ажилласан. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын трасс дагуу мал амьтны нүхэн гарц – 12 ш, дам нуруут гүүр – 8 ш, жаазан гүүр – 7 ш, ачааны тэрэг нэвтрүүлэх гүүр – 1ш, зэрлэг, мал амьтанд зориулсан нэг түвшний шороон гарам (өргөн 30м) – 10 ш буюу нийт 37 ш байгууламжийг Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандартын дагуу хийсэн.

Зэрлэг амьтанд зориулсан биотехникийн арга хэмжээнд Цогтцэций сум болон Баян-Овоо сумдад тус бүр 50 боодол өвс, Ханбогд суманд 30 боодол өвс, Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд 450 боодол өвс тус тус хүлээлгэн нийт 580 боодол өвсийг өгч аргаль, янгир зэрэг зэрлэг ан амьтдад тархасан нутгуудад тараан байршуулав. Зэрлэг амьтдын усалгаанд зориулан нарны системээр ажилладаг ус өргүүр бүхий дэвшилтэт технологитой инженерийн хийцтэй 2 худаг шинээр гарган тухайн орон нутагт хүлээлгэн өгсөн.

Бөөрөлжүүтийн уурхай, цахилгаан станцын цогц төсөл

Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК

“Цэцэнс Майнинг энд Энержи” компани бүх чиглэлээрээ байгальд ээлтэй, эко шийдэл бүхий шинэлэг нөү-хау, инноваци, дэвшилтэт технологийг нэвтрүүлж, үйл ажиллагааны нөлөөллөөс үүдэх сөрөг үр дагаврыг бууруулах болон урьдчилан сэргийлэхийг эрхэм зорилгоо болгож ажилладаг.

Тус компани ногоон хөгжлийг дэмжих, тогтвортой үйл ажиллагааг төлөвшүүлэхэд чиглэсэн бодлогыг түүштай хэрэгжүүлж, байгаль орчинд хариуцлагатай байгууллага байхаар зорьж байна.

Үйл ажиллагаануудынхаа хүрээнд холбогдох хууль тогтоомж болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олборлолт, үйлдвэрлэлийн нийтлэг тэргүүн түршлагыг дагаж мөрдөж Байгаль орчинд хохирол учруулахаас урьдчилан сэргийлж, компанийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг нийгмийн хэрэгцээ шаардлага, эдийн засгийн хүчин зүйлсийг харгалзан хүрч болохуйц боломжит доод түвшинд байлгаж тогтвортой хөгжлийг дэмжиж ажиллахад оршино.

Зорилтууд:

- Монгол улсын холбогдох хууль тогтоомжууд болон олон улсад нийтээр хүлээн зөвшөөрсөн байгаль орчны стандартуудыг дагаж мөрдөнө.
- Байгаль орчныг хамгаалах ажлын гүйцэтгэлийг байнга сайжруулна.
- Нутгийн ард иргэдийн уламжлалт соёл, өв уламжлалыг хүндэтгэж хамгаална.
- Байгаль орчинд халгүй, үйл ажиллагааны үр ашгийг тогтмол дээшлүүлэх шинэ дэвшилтэт технологийг хөгжүүлэх, нэвтрүүлэхийг эрмэлзэнэ.
- Төрөл бүрийн модтой мод үржүүлгийн газар – эх ургамлын талбай буюу палантациудыг бий болгох





Бөөрөлжүүтийн уурхай, цахилгаан станцын цогц төсөл

Байгаль орчны нөхөн сэргээлт, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байдал

Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК нь үйл ажиллагаанаа бүхий л үе шатанд байгалийн баялгийн зүй зохистой, үр өгөөжтэй ашиглалт, байгаль орчны хамгааллыг тэргүүлэх чиглэлүүд болгож, эрчим хүч хэмнэх, хог хаягдлыг бууруулах, нөөцийн хариуцлагатай менежментийн туршлагыг хэрэгжүүлэх замаар төслийн экологид үзүүлэх нөлөөллийг багасгаж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган ажилладаг. Энэхүү бодлогын хүрээнд 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулахдаа 2019 оны 10 сарын 29 – ний өдрийн БОАЖЯ-ны сайдын А/618 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ийг удирдлага болгон компанийн үйл ажиллагаандаа уялдуулан 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны ХБОБНУГ-аар батлуулан хэрэгжүүлэн ажилласан.

Техникийн болон биологийн нөхөн сэргээлт

2025 онд Бөөрөлжүүтийн хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн хэмжээнд биологийн 2.2 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж, хөдөө аж ахуйн чиглэлээр MNS 5918:2023 стандартын дагуу тус бүсэд зонхилох бэлчээрийн олон наст ургамал болох царгас, согоовор, ерхөг, дагуур өлөнгө зэргийг хольж тарьсан.

Дэвшилтэт технологи ба үйлдвэрлэлийн шийдэл

Байгаль орчны гүйцэтгэлийн хувьд нүүрсний бүрэн шаталт бүхий CFB зуух, утааны хийн хамгийн өндөр ашигт үйл бүхий цахилгаан статик шүүлтүүр, усны “тэг” алдагдал бүхий агаарын хөргөлттэй конденсатор, 220кВ-ын түвшний хийн тусгаарлагатай хаалттай хуваарилах байгууламж, тоосжилт бууруулах инженерийн шийдлүүд, үйлдвэрийн болон ахуйн хаягдал үс цэвэрлэх систем зэрэг орчин үеийн технологиудыг нэвтрүүлснээр станцын үйл ажиллагаа олон улсын стандарт шаардлагад нийцэн ажиллаж байна.

Хог хаягдлын менежмент

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүсэх бүх төрлийн хог хаягдлыг ангилан ялгаж, багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах, аюулгүй хадгалах, стандартын дагуу зайлуулах тогтолцоог бүрдүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, байгаль орчинд учрах нөлөөллийг бууруулан дахин ашиглах, боловсруулах хог хаягдлын хэмжээг жил бүрээр нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна. 2025 онд дахин боловсруулахаар 18,360 тн үнс шаарганы хаягдалыг бетоны үйлдвэрт түүхий эдээр, 1,065,650 тн төмрийн хаягдлыг боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн.

Аюултай хог хаягдлын менежмент

Хог хаягдлын тухай хууль холбогдох стандартын дагуу, аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, шатаах, устгах тусгай зөвшөөрөл бүхий төвлөрсөн байгууламж болох “Элэмент” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 19 тн хог хаягдалыг устгалд оруулсан.

2025 онд



2,2га

Талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн.

Ногоон байгууламж, ойжуулалт

Төслийн үйл ажиллагаа хэрэгжиж буй нутгийн бүс, бүслүүрийн экологийн онцлогт тохируулан, шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөлтийн дагуу ойжуулалт болон ногоон байгууламжийн ажлыг хэрэгжүүлэх зорилгоор

2025 онд

13,000 ш

Бут сөөгийг тарьж ургуулсан.

20,000+

Палантацийн талбайгаа нэмэгдүүлсэн.

Бөөрөлжүүтийн уурхай, цахилгаан станцын цогц төсөл

Байгаль орчин, нөхөн сэргээх үйл ажиллагааны хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд манай хамт олон 2021 оноос эхлэн жил бүр мод, бут сөөг тарьж ургуулах ажлыг эхлүүлсэн бөгөөд Улиасны 20,000 ширхэг тайрдас тарьж, үржүүлсэн бургаснаас 3,000 ширхэг бургасыг уурхайн шүүрлийн уснаас тогтсон нуурын эрэг орчимд хашаалан, нийт 23,000 ширхэг мод тарьсан. 2025 онд гэхэд 3 удаагийн бүх нийтээр мод тарих өдөрлөгийг амжилттай зохион байгуулж, 13,000 ширхэг бут, сөөг тарьж ургуулан мод үржүүлгийн талбайгаа 20,000 гаруй ширхгээр нэмэгдүүллээ. Энэ нь 7 хөл бөмбөгийн талбайтай тэнцэхүйц талбайг ойжуулах хэмжээний үр дүн бөгөөд байгаль орчныг хамгаалах, ногоон бүсийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан үзүүлэлт болсон. Төв аймгийн Баянжаргалан сумын ЗДТГазар, Баянжаргалан сумын нөлөөллийн бүсийн иргэдтэй хамтран манай хамт олны санаачилгаар Хамтын

оролцоотой Байгаль орчны мониторингийн ажлыг 2022 оноос эхлүүлэн, амжилттай үргэлжилж байна. Энэ ажлын хүрээнд сум, иргэд, аж ахуйн нэгж нь байгаль орчны сөрөг нөлөөллийн үл ойлголцлуудыг арилгаж, нэгдсэн нэг ойлголтод хүрч, цаашид хамтран ажиллахаар болсон. Үүний дагуу 2023 оны 6-р сард Киргиз улсын Байгаль орчны салбарын Сайд, төлөөлөгчид ХОБОМ-ийн багийн үйл ажиллагаа, хэрэгжилттэй танилцаж түршлага хуваалцсан билээ. Бөөрөлжүүтийн уурхайн шүүрлийн ус нь инженерчлэлийн сувгийн дагуу нийт 71 км урсахдаа, 5 нуурыг үүсгэж, Хэрлэн голтой нийлдэг. Ингэж урсахдаа Архуст суманд байрлах Бөөрөлжүүтийн рашааны ундаргыг сэргээж, нөхөн төлжүүлсэн. Цаашлаад Архуст, Баянжаргалан сумдын бэлчээр дэх мал, амьтныг үндны цэвэр усаар хангаж байгаа төдийгүй ил усыг даган бусад аймаг, сумдаас отрын малчид ихээр ирдэг болсон. Дүйцүүлэн хамгаалах ажлын

хүрээнд Төв аймгийн Баян сумын Сант багийн рашааны эхийг хашиж хамгаалах, мөн тус сумын цэцэрлэгт хүрээлэнд нь зориулж 3,500 ширхэг модны суулгацыг хүлээлгэж өгсөн. Баянжаргалан сумын угтах хаалганы орчим 3,000 ширхэг навчит модыг өөрсдийн хөрөнгө оруулалт, хүн хүчээр тарьж өгсөн. Хог хаягдлын менежментийн ажлын хүрээнд аюултай хог хаягдлын тусгай зөвшөөрөлтэй компаниудтай гэрээ байгуулан хамтарч, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүсэх бүх төрлийн хог хаягдлыг ангилан ялгаж, багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах, аюулгүй хадгалах, стандартын дагуу зайлуулах тогтолцоог бүрдүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, байгаль орчинд учрах нөлөөллийг бууруулан дахин ашиглах, боловсруулах хог хаягдлын хэмжээг жил бүрээр нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна.

2025 онд

13,360 тн

Үнс шаарганы хаягдлыг бетоны үйлдвэрт түүхий эдээр

1,065,650 тн

төмрийн хаягдлыг боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн.

Сэлбэ голын эхэнд хиймэл нуур байгуулах төсөл

"Сэлбэ голын эх хамгаалах" төслийн хүрээнд 11га талбайд хиймэл нуур байгуулж, урсац тохируулга, тохижилт, барилгын ажлуудыг гүйцэтгэв.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

- Хаврын шар ус болон хур тунадасны үерийн усыг хуримтлуулж, тохируулан үерийн эрсдэлээс сэргийлэх
- Ой, хээрийн түймрийн үед ашиглах усны нөөц бүрдүүлэх
- Иргэдэд байгальд ойр аялал, амралтын орчин бүрдүүлэх



Техникийн үзүүлэлт:

863м


Далангийн урт

11га

Нуур мандлын талбай

280,000м³

Усны эзэлхүүн



Жавхлант нуурын төсөл

“Цэцэнс Майнинг энд Энержи” компани Бөөрөлжүүтийн уурхайн олборлолтын явцад үүссэн шүүрлийн усыг ашиглан 5 га талбайд хиймэл нуур байгуулж, усны нөөцийг нөхөн бүрдүүлэх шийдлийг хэрэгжүүлээд байна. Энэхүү нуур нь зөвхөн ус хуримтлуулах бус, бүс нутгийн усны шинэ экосистемийг сэргээж, нүүдлийн болон суурин усны шувуудын амьдрах таатай орчныг бүрдүүлэв.

Судалгаагаар өвөгт тогоруу, ангир, хондон ангир, гангар хун, улаан хүзүүт шумбуур зэрэг ховор, хамгаалалт шаардлагатай шувууд тогтмол нутагшиж буй нь тогтоогдсон. Мөн усан орчинд загас, ургамал, бичил биетүүд өсөж үржин, экосистемийн тэнцвэр сэргэж, орон нутгийн мал сүргийн ундны усны найдвартай эх үүсвэр болж байна. Ийнхүү байгальд ээлтэй усны менежмент нь уурхайн үйл ажиллагааг тогтвортой хөгжилтэй уялдуулах бодит жишээ болж буй юм.





Нүүдлийн шувуудын шинэ амьдрах орчин

Бөөрөлжүүт уурхайн шүүрлийн усыг ашиглан байгуулсан Жавхлант нуур нь нүүдлийн шувуудын амьдрах орчныг дэмжиж, биологийн олон янз байдлыг хамгаалахад бодит хувь нэмэр оруулж байна.

Жил бүр олон мянган километр зам туулдаг нүүдлийн шувуудын хувьд аюулгүй түр буудаллах, амрах, хоол тэжээлээ нөхөх ус намгархаг орчин нэн чухал. Жавхлант нуур нь тэдний амьдрах таатай орчныг бүрдүүлэхийн зэрэгцээ тухайн бүсийн экологийн тэнцвэрийг сайжруулж, усны экосистемийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлж байна.

Шувууд олноор нутагшин ирэх нь тухайн орчны экологийн эрүүл байдлыг илтгэхээс гадна ургамал, амьтны аймгийн олон төрөл зүйл сэргээн тогтоход чухал нөлөөтэй. Мөн усны экосистем нэмэгдэх нь хөрсний чийгийг хадгалах, тоосжилтыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх зэрэг байгаль орчны олон ач холбогдлыг бий болгодог.





1 жилд

100,000–1,000,000 ₮

Модны тарьц, суулгац бойжуулах хүчин чадал бүхий орчин үеийн төвийг тогтвортой ажиллуулж байна.



Тогтвортой ойн аж ахуй, байгаль хамгааллыг дэмжсэн бодит хөрөнгө оруулалт

2020 онд Бодь Групп ногоон хөгжил, байгаль орчны тогтвортой байдлыг дэмжих зорилтын хүрээнд ойн мэргэжлийн байгууллага болох "Домогт Шарын Гол" ХХК-д хөрөнгө оруулалт хийж, урт хугацааны хамтын ажиллагааг эхлүүлсэн. "Домогт Шарын Гол" ХХК нь 1996 онд ойжуулалт, ой нөхөн сэргээлт, мод үржүүлгийн чиглэлээр байгуулагдсан бөгөөд олон жилийн туршлагатай мэргэжлийн баг хамт олонтойгоор Монгол орны ойн экосистемийг хамгаалах, сэргээх үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлж байна.

Бодь Группийн ажилтнууд "100 Зуун Мод" төслийн хүрээнд "Хөдөлмөр зуслан" хөтөлбөрт тогтмол оролцож, мод бортоглох, тарьц арчлах зэрэг ажлаар дамжуулан ойн салбарын хөгжилд бодит хувь нэмэр оруулдаг. Тус байгууллага нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дахь Домогт бүсэд 3,691 га ойн сангийн газрыг гэрээгээр эзэмшин хамгаалалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа хэрэгжүүлж байна. Үүний хүрээнд нас бие гүйцсэн 15 га таримал ойг улсын ойн санд хүлээлгэн өгсөн бөгөөд өнөөдөр уг талбай нь саглагар мөнх ногоон нарсан ой болон төлөвшөөд байна. Мөн "Домогт Шарын Гол" ХХК нь 2015-2018 онд Бүгд Найрамдах Чех Улсын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн "Монгол орны ой болон орон нутгийн ойн генийн сангийн хөгжил" төслийг амжилттай хэрэгжүүлж,

10 жилийн тогтвортой ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулсан.

Төслийн үр дүнд "Ойн гайхамшиг" мод үржүүлгийн төвийг байгуулж, жилд 100,000–1,000,000 ширхэг модны тарьц, суулгац бойжуулах хүчин чадал бүхий орчин үеийн төвийг тогтвортой ажиллуулж байна.






100 Зуун Мод төсөл

Бодь Группийн ажилтнууд "100 Зуун Мод" төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн "Домогт Шарын гол" ойн мэргэжлийн байгууллагын мод үржүүлгийн газарт мод тарих ажилд сайн дураар оролцож, байгальдаа хөрөнгө орууллаа.

Тус төслийн санаачилга нь ажилтнуудын байгаль орчны оролцоог нэмэгдүүлэх, ойжуулалт, ногоон байгууламжийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариуцлагатай үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэхэд чиглэлээ.

Мөн мод тарих ажлыг тогтмол хэрэгжүүлснээр хөрсний доройтлыг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах, нүүрстөрөгч шингээлтийг нэмэгдүүлэх зэрэг урт хугацааны экологийн эерэг үр нөлөөг бий болгож байна.



2024 онд
 **1,010** мод
 Хоёр ээлжээр ажиллаж тарьсан бол

2025 онд
 **2,168** мод
 Нэг ээлжээр ажиллаж тарьсан.





Байгальд ээлтэй, ногоон ирээдүйг бид хамтдаа бүтээж байна

Байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор Бодь Групп жил бүр уламжлал болгон хэрэгжүүлдэг "100 Зуун Мод" төслийн хүрээнд 2025 онд нийт 500 гаруй ажилтан болон 355 гэр бүлийн гишүүд нэгдэн, хамтдаа 10,945 мод тарилаа. Энэхүү санаачилгын үр дүнд жил бүр дунджаар 1,300 тонн хүчилтөрөгч ялгаруулж, 230 тонн нүүрстөрөгчийн хийг шингээж байгальд бодит хувь нэмэр оруулж байна. Тарьсан мод бүр амьд ургалттай, бүртгэлжсэн бөгөөд ухаалаг усалгааны системийн хяналттайгаар ургаж буй нь төслийн онцлог юм. Цаашид бид ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг үе шаттайгаар өргөжүүлж, эх дэлхийдээ ээлтэй, ногоон ирээдүйг хамтдаа бүтээх зорилтоо түүшгүй хэрэгжүүлсээр байх болно.



2025 онд



500 гаруй

Ажилтан



355

Гэр бүлийн гишүүд



10,945 мод


тарилаа

Ойн сангийн цэвэрлэгээ хийж, экосистемийн тэнцвэрийг дэмжив.

“Рэд Рок Холдинг” компани нь 2025 оны 3 дугаар сард “Хар хад” зочид буудлын төслийн хүрээнд Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Чандмань-Өндөр сумын нутаг дахь Хөвсгөл нуурын зүүн эргийн ойн бүсэд 104 м³ хэмжээтэй ойн цэвэрлэгээний ажлыг гүйцэтгэлээ.

Ойн цэвэрлэгээ нь хатсан, унасан болон өвчилсөн моддыг цэвэрлэх замаар ой, экосистемийн эрүүл байдлыг хадгалах, ой хээрийн түймрийн эрсдэлийг бууруулах, хортон шавжийн тархалтаас сэргийлэх, шинэ үргалтыг дэмжихэд чухал ач холбогдолтой юм. Мөн ойн нягтаршлыг зохистой түвшинд хадгалснаар биологийн олон янз байдлыг хамгаалах, хөрс, усны нөөцийн тогтвортой байдлыг дэмжих эерэг нөлөө үзүүлдэг.

Энэхүү ажил нь байгаль орчны хариуцлагатай менежментийг хэрэгжүүлэх, аялал жуулчлалын хөгжлийг байгаль хамгаалалтай уялдуулах, тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжихэд чиглэсэн санаачилгын нэг хэсэг юм.



“Бөөрөлжүүт Цахилгаан станц”-ын бүсэд 4,650 мод тарьж ногоон орчныг нэмэгдүүлэв.

“Цэцэнс Майнинг Энд Энержи” ХХК нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж “Go Green” аяныг эхлүүлэн Бөөрөлжүүт цахилгаан станцын бүсэд ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүллээ.

2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр станцын оффис болон зэргэлдээх нуурын орчимд нийт 4,650 мод тарьсан бөгөөд үүнд 1,350 ширхэг шар хуайс, 3,300 ширхэг бургас суулгасан байна.


Мөн орчны хог хаягдлыг цэвэрлэж, цогц их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулжээ. Аяны хүрээнд хаврын улиралд нийт 32,000 ширхэг мод, бут сөөг тарих төлөвлөгөөтэй бөгөөд 5,900 бут сөөг, 1,000 мандлын цэцэг, 20,000 улиас, 1,000 гаруй шилмүүст мод болон 5,000 гоёлын бут сөөгийг үрээр үржүүлэхээр ажиллаж байна.

Энэхүү санаачилга нь биологийн олон янз байдлыг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах замаар тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулж байна.



Нийгэм

Хүн төвтэй хөгжлийг эрхэмлэн, хамтын үнэ цэн бүтээж,
нийгмийн сайн сайханд хувь нэмэр оруулна.



Бөөрөлжүүт цахилгаан станц 300 МВт хүчин чадлаар цахилгаан, эрчим хүч нийлүүлж байна

Бодь Группийн хэрэгжүүлж буй Бөөрөлжүүт цахилгаан станцын 150 МВт-ын хүчин чадалтай хоёрдугаар блок 2025 оны 10 дугаар сарын 18-нд Төвийн бүсийн эрчим хүчний системд холбогдон цахилгаан эрчим хүч нийлүүлж эхэллээ. Ингэснээр тус станц нийт 300 МВт-ын хүчин чадлаар ажиллаж, Монгол Улсын эрчим хүчний системд тогтвортой нийлүүлэлт хийж байна.

Бөөрөлжүүт цахилгаан станц бүрэн хүчин чадлаар ажилласнаар 963 мянган айл өрхийн хэрэглээг хангах хэмжээний цахилгаан үйлдвэрлэх боломж бүрдэж, эрчим хүчний хязгаарлалтыг бууруулах, импортын хамаарлыг багасгах, эрчим хүчний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд бодит хувь нэмэр оруулж байна. Түүнчлэн өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэгцээг дотоодоос хангах замаар эдийн засгийн тогтвортой өсөлт, үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагаа, иргэдийн амьдралын чанарыг дэмжих чухал дэд бүтэц болж байна.

Бөөрөлжүүт цахилгаан станц 2025 оны 12 дугаар сарын 2-нд буюу ашиглалтад орсноосоо хойш 1 жил хүрэхгүй хугацаанд 1 тэрбум кВт.ц цахилгаан үйлдвэрлэжээ. Ингэснээр өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээг хангах, хэрэглээний хязгаарлалтыг бууруулах, импортын эрчим хүчнээс хамаарал багасгах, хэрэглэгчдийг тасралтгүй, найдвартай эрчим хүчээр хангах чиглэлд Монгол Улсын эрчим хүчний салбарт томоохон хувь нэмэр оруулж байна.

Бөөрөлжүүт цахилгаан станц нь зөвхөн эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг нэмэгдүүлээд зогсохгүй Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжихэд бодит хувь нэмэр оруулж байна.

Дотоодын эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлснээр эрчим хүчний аюулгүй байдлыг бэхжүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, үйлдвэрлэл үйлчилгээний тасралтгүй ажиллагааг хангах суурь нөхцөлийг бүрдүүлж буй юм.

Мөн эрчим хүчний хангамж тогтвортой байх нь иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, ажлын байр бий болгох, бүс нутгийн хөгжлийг дэмжих зэрэг нийгэм, эдийн засгийн олон зэрэг үр нөлөөг дагуулж байна. Үүний зэрэгцээ орчин үеийн технологи, үр ашигтай ажиллагааг үе шаттай нэвтрүүлснээр эрчим хүчний салбарын бүтээмж, хариуцлагатай хөгжлийг дэмжихэд чухал ач холбогдолтой юм.



1 ТЭРБУМ КВТ.Ц
цахилгаан үйлдвэрлэлээ

963,000 ӨРХИЙГ
цахилгаанаар хангах боломж бүрдсэн





Хүүхэд, гэр бүлийн үнэ цэнийг дэмжигч Үндэсний соёл амралтын хүрээлэн (Хүүхдийн парк)

Бодь Групп нь Улаанбаатар хотын иргэд, хүүхэд багачууд, гэр бүлд зориулсан ногоон байгууламж, амралт, соёлын хүртээмжтэй орчныг хадгалан хөгжүүлэх зорилгоор Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн үйл ажиллагаанд тогтмол хөрөнгө оруулалт хийж, шинэчлэл сайжруулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Үндэсний соёл амралтын хүрээлэн нь олон арван жилийн турш нийслэлийн иргэдийн чөлөөт цаг, хүүхэд гэр бүлийн амралт, соёлын үйлчилгээний төв байсаар ирсэн бөгөөд Бодь Групп тус паркийн үндсэн зориулалт, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн орчныг хадгалан хамгаалах чиглэлд тогтвортой анхаарч ажилладаг.

Тус хүрээлэнд хүүхдийн тоглоомын талбай, амралт, зугаа цэнгэлийн байгууламжуудын шинэчлэл, тохижилт, аюулгүй ажиллагаа, ногоон байгууламжийн арчилгаа хамгаалалтыг тогтмол хэрэгжүүлж, иргэдэд аюулгүй, тав тухтай, хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтуудыг хийсээр байна. Мөн паркийн ногоон байгууламж, мод, ургамлыг хамгаалах, хотын төвийн үнэ цэнтэй нийтийн эзэмшлийн газрын зориулалтыг хадгалах чиглэлд үрт хугацаанд тууштай ажиллаж ирсэн нь Улаанбаатар хотын тогтвортой хөгжил, хотын экологийн тэнцвэрт байдалд бодит хувь нэмэр оруулж байна. Цаашид Үндэсний соёл амралтын хүрээлэнг хүүхэд, гэр бүл, олон нийтэд зориулсан орчин үеийн, байгальд ээлтэй, хүртээмжтэй ногоон орчин болгон хөгжүүлэх зорилтын хүрээнд шинэчлэл, хөрөнгө оруулалтын ажлуудыг үе шаттайгаар үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Үндэсний соёл амралтын хүрээлэн нь 2025 онд хог хаягдлын ангилан ялгалтыг тогтмол хэрэгжүүлж, оюутан залуусыг цагийн ажлын байраар хангах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажилласан. Түүнчлэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг үйл ажиллагааныхаа бүхий л түвшинд мөрдөж, ажилтан, үйлчлүүлэгчдийн аюулгүй орчныг бүрдүүлэхэд анхааран ажиллав.



Үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэгч “Түмэн Эх” чуулга

Бодь Групп нь Монголын үндэсний урлаг, соёлын өвийг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн дэргэд “Түмэн Эх” чуулгын үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. 1989 онд байгуулагдсан “Түмэн Эх” чуулга нь өнөөдрийг хүртэл тогтвортой үйл ажиллагаа явуулж, мэргэжлийн уран бүтээлчид болон ардын авьяастнуудаас бүрдсэн чадварлаг хамт олныг бүрдүүлэн ажиллаж байна. Тус чуулга нь ардын болон орчин үеийн урлагийн баялаг урын сантай бөгөөд Монгол Улсын бүх аймагт төдийгүй дэлхийн 50 гаруй улсад аялан тоглолт хийж, үндэсний урлагийг олон улсад сурталчлан таниулсаар ирсэн. Чуулгын урын сан нь ардын богино болон уртын дуу, үндэсний хөгжмийн бүтээлүүд, бий биелгээ, олон ястны бүжиг, цамын бүжиг, хөөмэй, язгуур урлаг, уран нугаралт зэрэг Монголын биет бус соёлын өвийн олон төрөл зүйлсийг багтаадаг.


Өнөөдөр 60 орчим уран бүтээлчтэйгээр тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. 2025 онд “Түмэн Эх” чуулгын барилга байгууламжийг шинэчлэн сайжруулж, уран бүтээлчдийн ажиллах орчин, үзэгчдийн тав тух, соёлын үйлчилгээний чанарыг олон улсын жишигт нийцүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт хийсэн. Энэхүү шинэчлэл нь үндэсний урлаг, соёлын өвийг ирээдүй үед өвлүүлэн үлдээх, олон нийтэд хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн урт хугацааны бодлогын нэг хэсэг юм.



Хүний нөөцийн стратеги: Хамтдаа хөгжих соёл

Бодь Групп нь 2025 онд хүний капиталд оруулах хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж, ажилтны сэтгэл ханамж, бүтээмж болон байгууллагын соёлыг тогтвортой хөгжлийн гол түлгүүр болгон ажиллалаа.

Шууд ба шууд бус ажлын байр 10,000+	Нийт ажилтан 2,400+	Шинэ ажлын байр 262	1 ажилтанд ногдох сургалт 13,4 цаг	Үйлдвэрлэлийн осолгүй ажилласан цаг 2,5 сая	ХЭМАБ сургалт 2,829.5 хүн цаг
---	-------------------------------	-------------------------------	--	---	---



ХҮНИЙ ЭРХ, ТЭГШ БОЛОМЖ БА ЗАСАГЛАЛ (GRI 405)

Бодь Групп нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, ёс зүйтэй засаглалыг хэрэгжүүлдэг.

Хөдөлмөрийн тухай хуулийн 142-р зүйл

Насанд хүрээгүй хүний хөдөлмөр эрхлэлтийг хатуу хориглож, бүх салбар компаниудад хяналт тавьж ажилладаг.

Хөдөлмөрийн тухай хуулийн 144-р зүйл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байрны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлогын арга хэмжээ авдаг.

Ялгаварлан гадуурхалтаас ангид байх

Ажилд авах, тушаал дэвших, цалин хөлс тогтооход хүйс, шашин шүтлэг, үндэс угсаагаар ялгаварлахгүй байх зарчмыг (GRI 405) мөрддөг.

“Bodi Voice” нээлттэй санал асуулгын системээр ирсэн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч долоо хоног бүр холбогдох хороодоор хэлэлцэн, 2025 онд 100% шийдвэрлэлтийн түвшинд ажиллав.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХҮЙ (GRI 403)

Бид “Осолгүй ажлын байр”-ыг эрхэмлэдэг.

Сургалтын хамрах хүрээ

2025 онд 12 төрлийн ХАБЭА-н сургалтад 913 ажилтан (давхардсан тоогоор) хамрагдаж, аюулгүй ажиллагааны соёлыг төлөвшүүлэв.

Урьдчилан сэргийлэлт

Төслийн талбарууд дээрх эрсдэлийн үнэлгээ, галын аюулгүй байдал болон анхны тусламжийн бэлтгэлжилтийг тогтмол хангасан.

Хүн төвтэй, ил тод, ёс зүйтэй удирдлага	Байгууллагын соёл, үнэт зүйлсийг төлөвшүүлэх	Тасралтгүй суралцагч хамт олон байх зорилго
Багийн ажиллагаа, оролцоог дэмжсэн соёл	Ажил, амьдралын тэнцвэрийг дэмжих бодлого	Бүтээлч санаачилга, инновацийг урамшуулах орчин

4B #BODI CULTURE PROGRAM

Бодь Групп ажилтнуудынхаа эрүүл, аз жаргалтай, сайн сайхан байдлыг дэмжих, бүтээмжийг дээшлүүлэх, бодит оролцоог хангах замаар байгууллагын эерэг соёлыг бүрдүүлэх зорилготой 4B цогц хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.



1. Be Healthy

Бид ажилтнууд болон тэдний гэр бүл, үр хүүхдүүдийн эрүүл мэнд, амьдралын сайн сайхан байдлыг дэмждэг.

- Health care WELL BEING
- HSE package
- Healthy lifestyle



Эрүүл мэндийн даатгал

Эрүүл мэндийн багц даатгал: 244 ажилтан, 130 гэр бүлийн гишүүнийг гэнэтийн осол, өвчлөлийн цогц 50 сая хүртэлх төгрөгийн багц даатгалд хамруулав.

BODI FIT 100

Эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх 100 хоногийн аянд 111 ажилтан оролцож, нийт 305.7 кг илүүдэл жин хасч, 46.4 кг булчингийн масс нэмсэн.


Нийгмийн хариуцлага

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, байгууллагын нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Монголын Хараагүйчүүдийн Массажийн Холбоо"-той урт хугацааны хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд тус хамтын ажиллагааны хүрээнд ажилтан, албан хаагчид давхардсан тоогоор нийт 696 удаагийн бариа заслын үйлчилгээнд хамрагдсан байна.

2. Be Happy

Бид ажилтнуудын сэтгэл ханамж, урам зориг, гэр бүлийн аз жаргалтай орчныг бүрдүүлэхэд анхаардаг.

- BODI Family
- Work & Life Balance Paid Days



Гэр бүлд ээлтэй бодлого

Группийн Санзайн аманд байрлах "Ойн булаг" зусланд ажилтнуудыг гэр бүлээр нь зуны улиралд амрах хөтөлбөр хэрэгжүүлдэг бөгөөд 2025 онд 40 гаруй ажилтан хамрагдсан.

Эрүүл мэнд, сайн сайхан байдал

Ажилтнуудын эрүүл мэнд, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих хүрээнд "Bodi Hiking" арга хэмжээг зохион байгуулж, группийн 8 компанийн 79 ажилтан 30 км-ийн явган алхалтад оролцон Монголын Явган Алхалтын Холбооны зэрэг, үнэмлэх авсан.


Цалинтай чөлөө

Ажилтнуудын сайн сайхан байдлыг дэмжих зорилгоор төрсөн өдрийн (жилд 1 өдөр), гэр бүлдээ зориулах (жилд 1 өдөр), эрүүл мэнддээ зориулах (жилд 4 өдөр), сургалт хөгжлийн (жилд 5 өдөр) цалинтай чөлөө олгодог. 2025 онд 3,000 гаруй ажилтан төрсөн өдрийн цалинтай чөлөөгөө эдэлсэн.

3. Build Engagement

Ажилтнуудын оролцоо, хөгжлийн боломж, багийн амжилтыг дэмждэг.

- BODI Talents
- BODI Events
- Employee Experience
- Flexible Work Arrangement
- Financial WELL - BEING



Ажилтанд ээлтэй, уян хатан ажлын орчин

Ажил, амьдралын тэнцвэрийг дэмжих зорилгоор 07:30–09:30 цагийн хооронд сонголттой ирэх цагийн зохицуулалт болон Microsoft 365 системд суурилсан зайнаас ажиллах боломжийг бүрэн хэрэгжүүлж байна.

Ажилтнуудын дотоод соёл, эерэг уур амьсгал

Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, ажилтнуудын харилцаа хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Bookaholic, Bodi Running, Soccer клубүүдийн үйл ажиллагааг тогтмол дэмжин хэрэгжүүлж, дотоод уур амьсгал, багийн нэгдмэл байдлыг нэмэгдүүлэхийг зорин ажиллаж байна.

"ТУС САН" хөтөлбөр

Ажилтнуудын санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих хүрээнд "ТУС САН" хөтөлбөрт хамруулж, нийт 40 ажилтны хуримтлалд 61.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

4. Build Insight

Амжилтын урамшуулал, карьер өсөлт, багийн амжилтыг үнэлдэг.

- Career Development
- BODI Synergy
- BODI Development fund
- Corporate governance
- Digitalization



Bodi Academy

Ажилтнуудын мэргэжлийн болон хувь хүний хөгжлийг системтэйгээр дэмжих зорилгоор – "Bodi Academy" –г үүсгэн байгуулж, группийн хэмжээнд PMP® хөтөлбөр, Сургагч багшийн хөтөлбөр болон Удирдах ажилтнуудын манлайллын хөтөлбөрийг хэрэгжүүлэв. Тайлант хугацаанд төслийн удирдлагын чадамжийг бэхжүүлэх хүрээнд PMP® Exam Prep 35 цагийн сургалтын хөтөлбөрт группийн 7 компанийн 40 ажилтан хамрагдаж, үүнээс 2 ажилтан олон улсын PMP® зэрэгтэй болсон.

Bodi Synergy

Группийн хэмжээнд хамтын ажиллагаа, мэдлэг солилцоо болон байгууллагуудын уялдаа холбоог бэхжүүлэх зорилгоор "Bodi Synergy" Удирдах ажилтнуудын зөвлөгөөн болон HR Meeting арга хэмжээг жил бүр зохион байгуулдаг. Энэхүү арга хэмжээ нь компаниудын шилдэг туршлага, мэдлэгийг хуваалцах, хамтдаа суралцан хөгжихийн зэрэгцээ группийн хэмжээнд хамтын ажиллагаа, харилцан уялдаа холбоо, нэгдмэл соёлыг бэхжүүлэх чухал талбар болж байна. Тайлант хугацаанд зөвлөгөөнд 12 компанийн 18 удирдах ажилтан, HR Meeting-т 11 компанийн 33 хүний нөөцийн ажилтан хамрагдсан.

Бодь группийн нэгдмэл соёл ба ажилтны оролцоонд суурилсан экосистем

Бодь Групп нь “Хүний хөгжил”-ийг тогтвортой өсөлт, урт хугацааны үнэ цэнийн үндсэн тулгуур гэж үзэн бизнесийн стратегийн салшгүй хэсэг болгон хэрэгжүүлж байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай (SDG 3, 4, 8, 11, 15, 17) уялдуулан бид ажилтан, тэдгээрийн гэр бүл, орон нутаг болон түншүүдийг нэгтгэсэн “Бодь-ийн соёл”-ыг төлөвшүүлэх зорилгоор группийн хэмжээнд 6 стратегийн хөтөлбөр хэрэгжүүлж байна. Эдгээр санаачилга нь ажилтны сайн сайхан байдал, хөгжлийг дэмжихээс гадна байгууллагын соёл, ёс зүй, хариуцлагатай засаглалыг бэхжүүлж буй тогтвортой хөгжлийн бодит практик болж байна.

ГРУППИЙН НЭГДМЭЛ СОЁЛ · ОНЦЛОХ 6 ХӨТӨЛБӨР



Стратеги: Манлайлал, инноваци болон БОНЗ-ийн дүү хоолой (SDG 4, 9)

Spotify болон YouTube, байгууллагын дотоод сүлжээгээр түгээгддэг BODICAST нь Бодь Группийн дотоод мэдлэг хуваалцах аудио платформ юм. Тус платформоор дамжуулан гүйцэтгэх удирдлагууд, охин компанийн мэргэжилтнүүд болон гадаад түншүүдийг урьж, корпорацын стратеги, ESG чиг хандлага, инноваци, технологийн хөгжил болон салбарын шилдэг туршлагын талаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлдэг. BODICAST нь байгууллагын мэдлэгийн соёлыг бэхжүүлэх, хамтын суралцах орчныг дэмжих, стратегийн ойлголтыг нийт ажилтнуудад хүртээмжтэй хүргэх чухал сүлжээн нэг болж байна.

24

дугаар

15,000+

Идэвхтэй сонсогч



Стратеги: Оюуны хөрөнгө оруулалт ба мэдлэг (SDG 4)

Бодь Группийн ажилтнуудын санаачилгаар хэрэгждэг BODI BOOKANOLIC нь уншлагын соёлыг түгээх, тасралтгүй суралцах орчныг дэмжих сайн дурын номын клуб юм. Клубийн хүрээнд сар бүр хамт олноороо олон улсын шилдэг бестселлер номуудыг хамтран уншиж, хэлэлцүүлэг өрнүүлэхээс гадна группийн хэмжээний дижитал номын сан, ажилтнуудын номын тойм нийтлэл, улирал тутмын номын уулзалтуудыг тогтмол зохион байгуулдаг. Энэхүү санаачилга нь ажилтнуудын мэдлэгийн хүрээг тэлэх, шүүмжлэлт сэтгэлгээ болон харилцан суралцах соёлыг бэхжүүлэх замаар байгууллагын оюуны капиталыг хөгжүүлэхэд чиглэж байна.

12

Онцлох ном

8

Салбар номын сан

350+

Идэвхтэй гишүүн



Стратеги: Тасралтгүй суралцах соёл ба Ур чадварын өсөлт (SDG 4, 8)

Бодь Группийн BODI ACADEMY нь ажилтнуудын мэргэжлийн болон хувь хүний хөгжлийг дэмжих нэгдсэн сургалт, хөгжлийн академи юм. Тус академи нь олон улсын болон дотоодын боловсролын байгууллагуудтай хамтран сертификаттай сургалтын хөтөлбөрүүд хэрэгжүүлэхийн зэрэгцээ залуу мэргэжилтэн, инженерүүдэд зориулсан “Future Leaders” менторшип хөтөлбөр, PMP® (Төслийн удирдлагын мэргэжилтэн) бэлтгэх сургалт болон ур чадвар ахиулах хөгжлийн хөтөлбөрүүдийг тогтмол зохион байгуулдаг. Мөн дижитал сургалтын платформ, тэтгэлэгт хөтөлбөр болон манлайллын хөгжлийн санаачилгуудаар дамжуулан тасралтгүй суралцах соёлыг төлөвшүүлж, байгууллагын ирээдүйн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэн ажиллаж байна.

72,000


Сургалтын цаг

13.4

Нэг ажилтанд

24

Мэргэжлийн тэтгэлэг



BODI SYNERGY

Стратеги: Охин компани хоорондын хамтын ажиллагаа ба Инноваци (SDG 8, 17)

BODI SYNERGY нь Группийн 9 охин компанийн хамтын ажиллагаа, мэдлэг туршлага солилцоо, инновацыг дэмжих нэгдсэн платформ юм. Хөтөлбөрийн хүрээнд "cross-functional" төслүүд, дотоод хакатон, "Best Practice Day" арга хэмжээг зохион байгуулж, нэг компанид амжилттай хэрэгжсэн ESG жишиг, дижитал шийдлүүдийг Группийн хэмжээнд түгээн нутагшуулдаг. Тухайлбал, ИНКОН ХХК, Бодь Пропертииз ХХК зэрэг охин компаниудын хэрэгжүүлсэн дижитал болон тогтвортой хөгжлийн туршлагыг бусад компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлснээр салбар хоорондын уялдаа холбоо, бүтээмж, хамтын үнэ цэнэ нэмэгдэж байна. Энэхүү санаачилга нь охин компаниудын бүрэн оролцоонд тулгуурлан инновацын соёл, тогтвортой өсөлт, хамтын хөгжлийг дэмжихэд чиглэдэг.

САЛБАР ХООРОНДЫН
ХАМТАРСАН ТӨСӨЛ

ОХИН КОМПАНИЙН
БҮРЭН ОРОЛЦОО.

BODI FIT 100 өөрийгөө өөрчлөх ХОНОГ

Стратеги: Эрүүл ажилтан - Тогтвортой бүтээмжэй ажилтан (SDG 3, 8)

BODI FIT нь ажилтнуудын бие бялдар, сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх цогц хөтөлбөр юм. Хөтөлбөрийн хүрээнд "Bodi Fit-100" жин хасах, булчин масс нэмэх аян, "Bodi Games", волейбол, сагсан бөмбөгийн лиг, "Mind Free" сэтгэл зүйн зөвлөгөө зэрэг олон талт үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлдэг.

2025 онд ажилтнуудын 45% нь хөтөлбөрт идэвхтэй хамрагдаж, жилийн хугацаанд 4 томоохон спортын арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд "Bodi Fit-100" аяны 4 дэх улиралд оролцогчид нийт 305.7 кг илүүдэл жин хасч, 46.4 кг булчин масс нэмсэн үр дүнг үзүүлсэн.

18%

Нийт ажилтнуудын

305,7 кг

илүүдэл жин хасч

46.4кг

булчин масс нэмсэн



Стратеги: Нийгмийн тогтвортой хөгжил ба Байгаль орчны хариуцлага (SDG 3, 11, 15)

BODI FAMILY DAY нь ажилтан болон тэдний гэр бүлийг нэгтгэх, байгууллагын эерэг соёл, нийгмийн оролцоог дэмжих Группийн уламжлалт арга хэмжээ юм. Хөтөлбөрийн хүрээнд хүүхдүүдэд зориулсан танин мэдэхүйн үйл ажиллагаа, Группийн бүтээн байгуулалтын төслүүдтэй танилцах аялал, урлаг спортын нэгдсэн наадам, гэр бүлээрээ оролцдог "100 Зуун Мод" мод тарих аяныг зохион байгуулдаг. 2025 онд тус арга хэмжээнд 1075 ажилтан, 355 гэр бүл оролцож, "100 Зуун Мод" аяны хүрээнд нийт 10,945 мод тарьж ургуулсан бөгөөд модны ургалтын түвшин 87%-тай байна. Тарьсан модны арчилгаа, усалгаа, нөхөн тарилтыг Группийн сайн дурын ажилтнууд болон орон нутгийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран тогтмол хэрэгжүүлдэг. Энэхүү санаачилга нь гэр бүлд ээлтэй байгууллагын соёлыг бэхжүүлэхийн зэрэгцээ байгаль орчны хариуцлага, ногоон оролцоог нэмэгдүүлэхэд чиглэдэг.

1075

Ажилтан

355

Гэр бүл

10,945 мод

тарьж ургуулсан



“BODI FAMILY DAY – 2025” арга хэмжээг амжилттай зохион байгууллаа

2025 оны 10 дугаар сарын 4-ний өдөр Бөөрөлжүүт цахилгаан станцын төслийн талбайд “BODI FAMILY DAY – 2025” арга хэмжээг зохион байгуулж, Бодь Группийн 7 компанийн 78 ажилтан болон **177 гэр бүлийн** гишүүд оролцлоо.

Арга хэмжээний хүрээнд оролцогчид Бөөрөлжүүт цахилгаан станц болон уурхайн үйл ажиллагаатай танилцаж, компанийн бүтээн байгуулалт, аюулгүй ажиллагаа, байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл авсан юм. Мөн “100 Зуун Мод” санаачилгын хүрээнд агч, хайлаас, голт бор, улиас зэрэг 4 төрлийн нийт **2,547 модны** суулгац тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулав.

Энэхүү үйл ажиллагаа нь ажилтнуудын оролцоо, гэр бүлийн үнэ цэнийг дэмжихийн зэрэгцээ байгаль орчны хамгаалал, ногоон хөгжлийн талаарх хамтын ойлголт, хариуцлагыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой боллоо. “BODI FAMILY DAY – 2025” арга хэмжээ нь байгууллагын соёлыг бэхжүүлэх, ажилтан, гэр бүлийн оролцоог дэмжих, тогтвортой хөгжлийн үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн санаачилга байв.





“Bodi Fit 100” хөтөлбөрөөр дамжуулан эрүүл амьдралын хэв маягийг түгээлээ

Бодь Группийн хамт олон эрүүл амьдралын хэв маягийг дэмжих зорилгоор уламжлал болгон хэрэгжүүлдэг “Bodi Fit 100” хөтөлбөрийн 3-р урилалд группийн 111 ажилтан амжилттай оролцлоо.

Оролцогчид 100 хоногийн турш зөв хооллолт, тогтмол дасгал хөдөлгөөн, сахилга бат, түүштай байдлыг амьдралын хэв маягтаа хэвшүүлсний үр дүнд нийт **305.7 кг** илүүдэл өөхний масс хаяж, **46.4 кг** булчингийн массыг нэмэгдүүлсэн амжилт үзүүллээ.





Power the Future!
Ирээдүйг асаана!



Ажлын байр нэмэгдүүлэх, оюутан сурагчдын дэмжлэг үзүүлэх хүрээнд:

Эрчим хүчний салбарын хөгжлийг бүтээлцэх ирээдүйн инженерүүдийг ажлын байранд бэлтгэх, мэргэжлийн боловсрол эзэмших үйл явцыг дэмжих зорилгоор "Оюутны тэтгэлэгт хөтөлбөр"-ийг 2024 оноос зарлан уламжлал болгон хэрэгжүүлж байна. 2024 он 5 оюутныг шалгаруулж сургалтын тэтгэлэг, цалинтай дадлага хийх урилга гардуулж өгсөнөөс, 2 оюутан сургуулиа төгсөөд Бөөрөлжүүт цахилгаан станцаас ажил хөдөлмөрийн гараагаа эхлүүлэн амжилттай ажиллаж байна.

Мөн бид Төв аймгийн Баян сумын харьяат жудо бөхийн спортын мастер, сурагч Б.Тэмүүлэнд 2025.08.26-2025.09.02-ны хооронд Болгар улсын Софи хотноо зохион байгуулагдсан Өсвөр үеийн дэлхийн аварга шалгаруулах тэмжээнд оролцоход нь санхүүгийн дэмжлэг үзүүлсэн бөгөөд тамирчин маань уг тэмцээнээс алтан медалийг хүртсэн.

ХАБЭА-н чиглэлээр хийгдсэн ажил, үр дүн:

2025 онд бид 1,300 хүний бүрэлдэхүүнтэйгээр цахилгаан станцын барилга угсралт, уул уурхай болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, нийт 2.5 сая хүн-цагийг осолгүй ажилласан байна. ХАБЭА-н стандарт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлсний үр дүнд давхардсан тоогоор 2,486 ажилтан сургалт, дадлага сургуулилтад хамрагдаж, нийт 5,015 хүн-цагийн сургалт зохион байгуулан ажилтнуудын эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадлыг сайжруулав. Ажлын байрны хяналтыг жилийн турш 1,500 удаа зохион байгуулж, 2,350 хүн-цаг зарцуулан аюулгүй ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ хийж, сайжруулах шаардлагатай чиглэлд хяналтаа төвлөрүүлэн эрсдлийг бууруун ажиллалаа.

Эрүүл ахуй, эрүүл мэндийн баг бүрэн бэлэн байдал ханган ажиллаж, 35,878 удаагийн урьдчилан сэргийлэх үзлэг, 14 удаагийн онц яаралтай тусламжийг цаг алдалгүй үзүүлж ажилтны эрүүл мэндийг хамгаалан ажилласан, мэргэжлийн аврах, гал унтраах баг орон нутагт гарсан хоёр удаагийн, нийт 157 м² талбайг хамарсан хээрийн түймрийг бүрэн унтрааж, мөн ойролцоох сумын төвд гарсан 69 метр хашаа, 100 боодол өвс шатсан галыг богино хугацаанд дарж, иргэдийн эд хөрөнгийн хохирлыг бууруулж ажилласан.

Эдгээр үр дүн нь уул уурхай, цахилгаан станцын өндөр эрсдэлтэй орчинд аюулгүй ажиллагааны тогтолцоог тогтвортой, үр ашигтай хэрэгжүүлж буйг нотлон харуулж байна.

Орон нутгийн хамтын ажиллагааны хүрээнд:

Уурхай, Цахилгаан станцын төслийн үйл ажиллагаа хэрэгждэг сумдүүдтай хамтын ажиллагааны гэрээг жил бүр байгуулан ажилладаг бөгөөд уг гэрээний хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгээд байна:

- Жил бүрийн өвлийн улиралд 3 сумын ахмад настан, амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой иргэдэд үнэгүй нүүрс олгодог.
- Сумдын төгсөх 9-р ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох, нутаг нь хэрэгжиж байгаа Уул уурхай, цахилгаан станцад санал болгодог ажил мэргэжлийн талаар таниулах, цаашид хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн талаар танилцуулах зорилгоор "Бидний Ирээдүй өдөрлөг"-ийг 3 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж байна.
- Сумдын өнгө үзэмж, тохижилтыг сайжруулах ажлын хүрээнд сумын угтах хаалга, танилцуулга самбар, гэрэлтүүлэг, мод зүлэг, саравч сандал, хогийн сав бүхий гадна хашааг барьж тохижуулах, техник, хүн хүч дайчлан цасанд боогдсон зам нээх хусах, сумдын хогийн цэг, малын сэг сэмийг түрэх булах, сумын тамгын газрын байр хүүхдийн тоглоомын талбай, хөл бөмбөгийн талбайн тохижуулалт, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, цаг уурын байр, сурагчдын дотуур байр зэргийн тохижилт, засвар үйлчилгээний ажлуудад дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан байна.
- Сумдын албан хаагчдад зөөврийн компьютер, эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмж багаж хэрэгслээр хангаж өгсөн.
- Аймаг болон сумдын ойн баяр, багийн өдөрлөг зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллаж ирсэн. Мөн төсөл эхлэх хугацаанд сумдын малчдаас мах, сүү зэргийн худалдан авалтыг хийж, малчдыг дэмжин ажилласан.



Ирээдүйн эрчим хүчний инженерүүдийг дэмжиж байна

“Цэцэнс Майнинг энд Энержи” ХХК нь эрчим хүчний салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, ирээдүйн инженер техникийн мэргэжилтнүүдийг бэлтгэх зорилгоор “Бөөрөлжүүт цахилгаан станц”-ын нэрэмжит оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг хоёр дахь жилдээ амжилттай хэрэгжүүллээ. 2025 оны хөтөлбөрийн хүрээнд магадлан итгэмжлэгдсэн 7 их, дээд сургуулийн 8 мэргэжлийн чиглэлийн III, IV курсын оюутнууд оролцоноос шилдэг 5 оюутан тэтгэлэгт шалгарч, сургалтын төлбөрийн дэмжлэг, цалинтай дадлага хийх боломж хүртэв.

Түүнчлэн төгсөөд “Бөөрөлжүүт цахилгаан станц” болон “Бодь” группт ажиллах боломж бүрдэж буй нь залуу мэргэжилтнүүдийг тогтвортой ажлын байраар хангах чухал алхам болж байна. Тус хөтөлбөр нь чанартай боловсролыг дэмжих, залуучуудын мэргэжлийн үр чадварыг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулж байна.

Мөн үйлдвэрлэл, боловсролын байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, салбарын хэрэгцээнд нийцсэн чадварлаг инженерүүдийг бэлтгэх тогтолцоог дэмжиж буйгаараа онцлог юм. Ирээдүйн хүний нөөцөд чиглэсэн энэхүү хөрөнгө оруулалт нь эрчим хүчний салбарын урт хугацааны тогтвортой хөгжил, инновац, мэдлэгт суурилсан өсөлтийн суурийг бүрдүүлж байна.



“Бидний Ирээдүй” хөтөлбөр

“Цэцэнс Майнинг энд Энержи” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд ерөнхий боловсролын 9-р ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох “Бидний Ирээдүй” хөтөлбөрийг жил бүр уламжлал болгон хэрэгжүүлдэг. 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Төв аймгийн Баян болон Баянжаргалан сумдын 32 сурагч, багш нар оролцож, компанийн үйл ажиллагаа болон эрчим хүч, уул уурхайн төслүүдтэй газар дээр нь танилцлаа.

Хөтөлбөрийн үеэр сурагчид инженер, мэргэжилтнүүдийн танилцуулга, туршлага хуваалцсан яриа болон асуулт хариултаар дамжуулан ирээдүйн мэргэжлээ сонгоход хэрэгтэй мэдлэг, ойлголт авч, сонирхсон асуултууддаа шууд хариулт авсан байна. Энэхүү хөтөлбөр нь залуу үеийн мэргэжил сонголтыг дэмжих, салбарын хүний нөөцийг бэлтгэх, боловсрол ба үйлдвэрлэлийн уялдааг сайжруулах замаар тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулж байна.



“GOOGLE MAPS - STREET VIEW” дэх Улаанбаатар хотын зураглалыг шинэчиллээ

GOOGLE MAPS - STREET VIEW - I

Дэлхий дахинаа интернэт хэрэглэгчдийн хамгийн өргөн хэрэглээ болсон Google maps, Google street view дэх Улаанбаатар хотын бүх гудамж, талбайн байр зүйн бодит зураглал, мэдээллийг шинэчлэх төслийг нийгмийн хариуцлагын хүрээнд “Бодь Интернэшнл” компани “Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газар”-тай хамтран хэрэгжүүллээ. Төслийн үр дүнд УБ хотын бодит дүр зураг, сүүлийн үеийн мэдээллийг интернэт хэрэглэгч бүр дэлхийн хаанаас ч цаг алдалгүй авах боломж бүрдэж байна. Улмаар УБ хотыг дэлхийд таниулан сурталчлах, монгол орныг зорих жуулчдын тоо нэмэгдэх, аж ахуйн нэгжүүд бизнесээ тэлэх зэрэг олон давуу тал бий болох юм. Төслийн хүрээнд багийнхан маань 4028.8 км замыг туулж, 750,360 панорама зургийг баталгаажуулан нийслэлийн 9 дүүргийн гудамж, зам талбай, барилга байгууламжийн 360° зураглал, AR буюу баяжуулсан бодит байдал, виртуал дүрслэл, нийтлэлийг “Google” платформд байршууллаа.

360 зураглал

4028 км
зам туулж

750,360
панорама зургийг
баталгаажуулан




9
дүүрэг, гудамж, зам
талбай, барилга

GOOGLE MAPS - STREET VIEW - II

Түүх, соёл, аялал жуулчлалын дурсгалт газруудын хүртээмжийг нэмэгдүүлэв

“Монголд зочлох жил” санаачилгын хүрээнд Хэнтий аймагт байрлах “Чингис хаан” аялал жуулчлалын цогцолбор болон байгаль, түүх, соёлын үнэ цэнтэй дурсгалт газруудыг “Google Maps”, “Google Street View”, “Google Business” платформд байршуулах ажлыг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүллээ. Энэхүү ажлаар Монгол дахь Google-ийн баг Хэнтий аймгаас үйл ажиллагаагаа эхлүүлж, бүс нутгийн аялал жуулчлалыг олон улсын түвшинд сурталчлах, орон нутгийн эдийн засгийн идэвхжилийг дэмжих суурь нөхцөлийг бүрдүүлэв.

Бодь Групп нь Монгол Улсын газрын зургийн мэдээллийг олон улсын дижитал платформ дээр шинэчлэх энэхүү төслийг тогтмол дэмжин ажиллаж байна. 2024-2025 онд төслийн багтай хамтран Улаанбаатар хотын гудамж, замын 360° зураглалыг шинэчилж, нийт 4,028.8 км авто замын дагуу 750,360 панорама зураг авч, Google Street View дахь нийслэлийн зураглалыг бүрэн шинэчилсэн. Энэхүү шинэчлэлийн үр дүнд Улаанбаатар хотын бодит, актуал мэдээллийг дэлхий нийтэд шуурхай хүргэх боломж бүрдэж, Монгол Улсыг олон улсад сурталчлах, аялал жуулчлалыг дэмжих, бизнесийн орчны хүртээмж, харагдах байдлыг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулж байна.



Өсвөр үеийнхний сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих зорилготой “MIND FREE” төсөл

“Бодь Интернэшнл” ХХК нь Монголын өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд анхаарал хандуулж, “Mind Free” төслийг “Их Өргөө Ротари клуб”-тэй хамтран хэрэгжүүлэв.

Төслийн хүрээнд Дундговь, Төв, Дархан-Уул аймаг болон Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулийн 7-12 дугаар ангийн 5,000 гаруй сурагчийг хамруулсан судалгааг зохион байгуулж, өсвөр насныханд тулгамдаж буй сэтгэл зүйн асуудал, донтолтын эрсдэлийг тодорхойлсон.

Судалгааны үр дүнд үндэслэн өсвөр үеийнхэнд сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, эцэг эх, асран хамгаалагч, сурган хүмүүжүүлэгчдийн сэтгэл зүйн боловсролыг нэмэгдүүлэх, орон нутгийн сэтгэлзүйч, эмч нарыг чадавхжуулах сургалт, гарын авлага боловсруулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлээ.

Төслийн судалгааны үр дүн нь “Advances in Public Health” олон улсын шинжлэх ухааны сэтгүүлд нийтлэгдсэнээр Монголын өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг олон улсын түвшинд хүргэх, цаашдын судалгаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал хувь нэмэр оруулаад байна.

“Mind Free” төсөл нь өсвөр үеийнхний сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, мэргэжлийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад чиглэсэн нийгмийн ач холбогдол бүхий төсөл боллоо.



Эх нялхаст цэвэр агаар бэлэглэлээ

Бодь Групп Smart Air Systems-ийн “Эх нялхаст цэвэр агаар бэлэглээ” төслийн санаачилгыг дэмжиж санхүүжилтийг шийдвэрлэн ажиллалаа. Монголын бяцхан үрс, ээжүүд, эмнэлгийн ажиллагсдыг нийслэлийн агаарын бохирдол, утаа, хорт хийн нэгдлүүдээс үүдэлтэй агаарын бохирдлоос хамгаалах зорилготой уг төслийн хүрээнд ЭХЭМҮТ-ийн агаар сэлгэлт нэн шаардлагатай Нярайн эмгэг судлалын 8 тасгийн 43 цонхонд ухаалаг агааржуулалтын төхөөрөмжийг суурилууллаа. ЭХЭМҮТ нь УБ хотын хамгийн их агаарын бохирдолтой бүсэд байрладаг. Барилгын үндсэн бүтэц, насжилт, таазны өндөр зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж агаар сэлгэлт нь стандартын дагуу шийдэгдэж чадаагүйгээс гадна өвлийн улиралд эмнэлгийн ачаалал 2 дахин ихсэж бохирдол ихтэй, бүгчим орчныг бий болгодог байна. Үүнээс үүдэлтэй дотоод агаарын чанарын зарим үзүүлэлт нь хүлцэх хэмжээнээс давсан үзүүлэлттэй байгаа нь эмчилгээний явцыг удаашруулах, өвчлөл хүндрэх шалтгаан болох, дөнгөж төрсөн нярайн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх зэрэг эрсдэлүүдийг үүсгэсээр ирсэн. Иймд Бодь Групп нь Монгол инженерийн шийдлээр зохион бүтээгдсэн Smart Air Systems төхөөрөмжийн туслалцаатайгаар тухайн нярайн тасгийн агаарын чанар, сэлгэлтийг сайжруулан эх, үрсийн эрүүл мэндийг хамгаалахад хувь нэмрээ оруулж байна.



Тасгийн эрхлэгч Г.Батцэнгэл:

Төхөөрөмжийг суурилуулснаар тасгийн агаарын чанарын үзүүлэлтүүд стандарт хэм хэмжээнд хүрч, эмчилгээний чанарт нөлөөлж, хүүхдүүдийн эмчлэгдэх хугацаа богиноссоноос гадна цонх хөлрөх, хана мөөгөнцөртөх зэрэг асуудлууд шийдэгдэж байна.

Smart Air Systems төхөөрөмж нь УБ хотын нөхцөлд тохируулан бүтээгдсэн бөгөөд HEPA болон идэвхжүүлсэн нүүрсэн шүүлтүүр ашиглан 99,9% шүүж цэвэрлэсэн агаарыг 24 цагийн турш тасралтгүй жигд цэвэр агаарын сэлгэлт хийх зориулалттай гэдгээрээ онцлогтой.

Тухайн төхөөрөмжийг ЭХЭМҮТ-д суурилуулахаас өмнө болон дараа ҮР ДҮНГ хэмжихэд:

- CO₂ Нүүрсхүчлийн хий – 1,730 буюу маш өндөр үзүүлэлттэй гарсан нь 1,019 болж буурав.
- O₂ Хүчилтөрөгчийн хэмжээ – 20-с 21 болж нэмэгдсэн бол Азотын хий – 11-с 5 болж буурав.



Эрчим хүчний хэмнэлттэй орон сууц



“Бодь Пропертиз” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд “Дулаан шийдэл II” төсөлтэй хамтран Сонгинохайрхан дүүргийн 7 болон 22 дугаар хорооны хоёр айлын байшинг бүтэн дулаалах санхүүжилтийг олгож, эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны шийдлийг дэмжин ажиллалаа. Төслийн хүрээнд байшингийн хана, дээвэр, суурийг бүрэн дулаалах, хаалга, цонхыг сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд үр дүнд нь 50 хувь болон түүнээс дээш хэмжээний эрчим хүчний хэмнэлт бий болсон байна. Мөн түлшний хэрэглээ буурч, өрхийн эдийн засагт эерэг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ дотор орчны агаарын чанар, амьдрах тав тух сайжирсан үр дүн гарчээ.

Энэхүү төсөл нь эрчим хүчний үр ашигтай хэрэглээг дэмжих, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, айл өрхийн амьдралын чанарыг сайжруулах замаар тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулж байна. Түүнчлэн сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг бодит хэрэглээнд нэвтрүүлэх сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ач холбогдолтой юм.



“Төмөр зам” хүүхдийн зурагт номын төсөл

“Бодь” группийн инженер, мэргэжилтнүүд Жангар редакцын уран бүтээлчидтэй хамтран “Төмөр зам” хүүхдийн зурагт номын төслийг амжилттай хэрэгжүүлж, хүүхэд багачуудын танин мэдэхүйд зориулсан боловсролын агуулгыг бүтээлээ. Энэхүү ном нь төмөр замын үүсэл, хөгжил, бүтээн байгуулалт, үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүүхдэд ойлгомжтой, сонирхолтой хэлбэрээр хүргэхээс гадна инженерчлэл, дэд бүтэц, тээврийн салбарын талаарх анхны ойлголтыг өгөхөд чиглэж байна. Мөн хүүхэд, өсвөр үеийнхний суралцах хүсэл эрмэлзэл, мэргэжил сонголтын чиг баримжааг дэмжих ач холбогдолтой юм.

Төсөл нь чанартай боловсролыг дэмжих, хүүхдийн танин мэдэхүйн хөгжилд хувь нэмэр оруулах, инженер техникийн мэргэжлийн үнэ цэнийг таниулах замаар тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэж байна. Үүний зэрэгцээ мэдлэг түгээх, ирээдүйн чадварлаг мэргэжилтнүүдийг бэлтгэхэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж буй санаачилга боллоо.

“Төмөр Зам” танин мэдэхүйн зурагт ном бяцхан уншигчдад хүрлээ


“Бодь Интернэшнл” ХХК-аас санаачлан “Жангар” редакцтай хамтран бүтээсэн “Төмөр Зам” номыг нийгмийн хариуцлагын хүрээнд “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн харьяа нийт 28 цэцэрлэг, 5 аймгийн “Ид шидийн орон” хүүхэд хөгжлийн төвүүд болон Өмнөговь аймгийн сумдын сургууль, цэцэрлэгүүдэд хандивлалаа.

Монголын ирээдүй болсон хүүхэд багачуудын боловсрол, танин мэдэхүйд үнэтэй хувь нэмэр оруулах энэхүү бүтээл нь хүүхдүүдэд төмөр замын талаарх анхны ойлголтыг сонирхолтой, бүтээлч хэлбэрээр хүргэх зорилготой. Цаашид компанийн зүгээс номын хүртээмжийг өргөжүүлж, илүү олон хүүхдэд хүргэхээр төлөвлөж байна.



Засаглал

Зарчмаа тэргүүнд эрэмбэлж, ил тод,
хариуцлагатай засаглалыг үлгэрлэн манлайлна.



Тогтвортой байдлын засаглал

Бодь Групп нь тогтвортой хөгжлийн зарчмуудыг компанийн стратеги болон өдөр тутмын үйл ажиллагаандаа бүрэн нэгтгэн хэрэгжүүлдэг. БОНЗ-ын хяналт нь Группийн хэмжээнд олон түвшинд хэрэгжих бөгөөд салбар бизнес, нэгжүүдийн хамтын ажиллагааг дэмжих, шийдвэр гаргалтад оролцогч талуудын ашиг сонирхлыг тусгахад чухал үүрэг гүйцэтгэдэг.


БОНЗ-ын засаглалын бүтэц ба чиг үүрэг

Төлөөлөн удирдах зөвлөл нь бизнесийн шийдвэр гаргалтад тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг тусгаж, БОНЗ-ын материаллаг асуудлуудын нөлөөлөл, эрсдэл, боломжуудад стратегийн хяналт тавьдаг. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь БОНЗ-ын санаачилгуудыг хянаж, зохицуулалтын нийцлийг хангах, эрсдэлийг удирдах замаар тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг санхүүгийн болон стратегийн зорилтуудтай уялдуулдаг.

Бодь Групп нь бизнесийн үйл ажиллагаа бүрдээ байгаль орчин, нийгмийн асуудлуудыг нэгдмэл байдлаар авч үздэг. Бизнес хариуцсан захирал нь БОНЗ-ын бодлогын хэрэгжилт, тайлагналыг удирдан зохион байгуулж, менежментийн багийн гишүүд өөрсдийн хариуцсан салбар, нэгжид тогтвортой байдлын хэрэгжилтийг ханган ажилладаг.

Группийн БОНЗ хариуцсан нэгж нь Бодь Интернэшнл ХХК-ийн Бизнес хөгжлийн газрын удирдлага дор ажиллаж, Группийн хэмжээнд тогтвортой байдлын гүйцэтгэлийг өдөр тутам хянаж, тайлагнадаг.

Энэхүү засаглалын бүтэц нь БОНЗ-ын асуудлыг шийдвэр гаргах түвшинд чухалчлан үзэх боломжийг олгодог.



Төлөөлөн Удирдах Зөвлөл

Гүйцэтгэх захирал



Стратеги, Хөрөнгө оруулалтын хороо



Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо



Ёс зүй, Комплайнсын хороо

Тайлагнах

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- БОНЗ-ын материаллаг асуудлуудыг бизнесийн үйл ажиллагаа, урт хугацааны стратеги төлөвлөлтөд нэгтгэн хяналт тавих.
- Стратеги болон зорилтот үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэрэгжилтийг хангах.

Хянах

Бизнес хөгжлийн газар БОНЗ ХАРИУЦСАН НЭГЖ

- Материаллаг байдлын үнэлгээг удирдан чиглүүлэх.
- БОНЗ-ын стратегийн чиглэлүүдийн хэрэгжилтийг салбар хооронд зохицуулах.
- Салбар компани, нэгжүүдийг шаардлагатай зөвлөмж, удирдамжаар хангах.
- Мэдээллийг нэгтгэж, оролцогч талуудад нээлттэй тайлагнах.

Бодь Групп нь тогтвортой байдлын засаглалын бүтцээр дамжуулан оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлон тогтоож, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих замаар тогтвортой хөгжлийг бизнесийнхээ салшгүй хэсэг болгон бэхжүүлж байна.

БОДЬ ИНТЕРНЭШНЛ ХХК

Байгаль орчин, нийгэм, засаглал(ESG) бодлого

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Бодь Интернэшнл ХХК (цаашид “Компани”) нь дэд бүтэц, эрчим хүч, барилга, үл хөдлөх хөрөнгө, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг групп компанийн хувьд урт хугацааны тогтвортой өсөлт, хариуцлагатай хөрөнгө оруулалт, олон улсын стандартад нийцсэн засаглалын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор энэхүү БОНЗ бодлогыг батлан мөрдөнө.

1.2. Энэхүү бодлого нь дараах олон улсын болон үндэсний стандарт, баримт бичигтэй бүрэн уялдсан байна.

1.3. Олон улсын

- 1.3.1. НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд (SDGs)
- 1.3.2. Global Reporting Initiative (GRI Standards)
- 1.3.3. ISO 9001:2015 (Чанарын удирдлага)
- 1.3.4. ISO 14001 (Байгаль орчны менежмент)
- 1.3.5. ISO 45001 (ХАБЭА)
- 1.3.6. ISO 26000:2012 (Нийгмийн хариуцлагын удирдамж)
- 1.3.7. ISO 31000:2018 (Эрсдэлийн менежмент)
- 1.3.8. ISO 37001 (Авлигатай тэмцэх удирдлагын тогтолцоо)
- 1.3.9. ISO 50001 (Эрчим хүчний менежмент)
- 1.3.10. ISO 27001 (Мэдээллийн аюулгүй байдал)
- 1.3.11. GHG Protocol (Хүлэмжийн хийн тооцоолол)

1.4. Үндэсний:

- 1.4.1. Монгол Улсын Үндсэн Хууль, БО-ны багц хууль
- 1.4.2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- 1.4.3. Монголын Тогтвортой Санхүүгийн Холбооны (ТОС) 8

зарчим

- 1.4.4. MNS 5914–5917 (Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт)
- 1.4.5. MNS 5918:2023 (Уул уурхайн БОYA)
- 1.4.6. MNS 6577 (Хариуцлагатай барилга)

1.5. БОНЗ зарчмыг компанийн дунд болон урт хугацааны стратеги, бизнес төлөвлөгөөн /OGSM/, охин компанийн тус бүрийн жилийн KPI/OGSM-д бүртгэн тусгана.

1.6. Компани нь Монгол Улсын “Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр”-ийн бичиг баримтын зарчим”-ыг үндэслэн боловсруулсан санал санаачилгыг дэмжин, зохион байгуулагдах нэгдсэн арга хэмжээнүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлж, компанийн үйл ажиллагаанд удирдлага болгон ажиллана.

1.7. Компани нь БОНЗ бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, холбогдох төсөв, төлөвлөгөөг боловсруулж удирдлагад танилцуулах, хэрэгжилтийг хянах чиг үүрэг бүхий “Тогтвортой хөгжлийн ажлын хэсэг”-тэй байна.

1.8. Компани нь Тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэж, чадавхжуулах ба шаардлагатай хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны төсвийг санхүүгийн төлөвлөгөөнд тусгаж ажиллана.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Энэ бодлого нь Бодь Интернэшнл ХХК болон түүний охин компаниуд, төслийн нэгжүүд, нийлүүлэгчид, гэрээт гүйцэтгэгчид энэхүү бодлогыг бүхий л үйл ажиллагаандаа

баримтлан ажиллана.

2.1.1. Охин компаниуд нь энэхүү бодлогын шаардлагыг өөрийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, дотоод журам, бодлоготой уялдуулан хэрэгжүүлж, хэрэгжилтийн тайланг тогтоосон давтамжаар группийн түвшинд тайлагнана.

2.2. Бодлого нь Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилт түүнтэй холбогдон гарсан эрх зүйн баримт бичгүүдтэй уялдсан байна.

3. НЭР, ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Энэхүү бодлогод хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

- 3.1.1. “Тогтвортой хөгжил” гэж хувь хүний болон байгууллагын хөгжлийн зорилтуудыг хангахын зэрэгцээ, Нийгэм, Байгалийн нөөц, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах чадварыг урт хугацаанд тогтвортой байлгах үйл явцыг,
- 3.1.2. “Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэл” гэж байгаль, орчны хүчин зүйл, уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх эрсдэл, нийгмийн харилцаанаас үүсэх эрсдэл болон компанийн засаглалын асуудлаас иргэн, хуулийн этгээдэд үүсэх эрсдэлийг,
- 3.1.3. “Байгаль орчин, нийгэм, засаглалын үнэлгээ” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний явцад хүн амын эрүүл мэнд, байгаль орчин болон амьдрах орчин, тэдгээрийн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөнд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилан тодорхойлох,

түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг,


4. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАЛААР БАРИМТЛАХ ЗАРЧИМ

4.1. Компани нь Нэгдсэн Үндэстний Байгууллага /цаашид “НҮБ” гэх/-ын “Тогтвортой хөгжлийн зорилт” түүнд хүрэх дэлхий нийтийн урт хугацааны бодлогын баримт бичигт заасан Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах зорилтыг хэрэгжүүлэхэд анхаарч, санхүүжилтийн хөшүүргийг ашиглах замаар хүлэмжийн хийн ялгаралтын хэмжээг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас учрах сөрөг нөлөө, эрсдэлийг багасгах, түүнд дасан зохицох үндэсний зорилтод хувь нэмрээ оруулна.

4.2. Монгол Улсын байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг даган мөрдөж ажиллана.

4.3. Уур амьсгалын чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдэд тавигддаг байгаль орчин, нийгмийн эрсдэлийн шаардлагууд нь энэ бодлогын салшгүй хэсэг болох бөгөөд эдгээр олон улсын байгууллагуудтай тогтоох хамтын ажиллагааны суурь бичиг баримтын адил тооцогдож, хүчин төгөлдөр үйлчилнэ.

4.4. Компани нь байгаль орчин, нийгэмд ээлтэй, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлийг дэмжих бодлого баримталж, Монгол Улсын Засгийн газрын хөгжлийн бодлоготой уялдан хариуцлагатай хөрөнгө оруулалт хэрэгжүүлнэ.



4.5. Олон улсын гэрээ хэлэлцээр, конвенц, Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон болон байгаль орчинд хор хөнөөл учруулах аливаа үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.

4.6. Компани нь нийт ажилтан, харилцагч, хамтран ажиллагч иргэд, байгууллагууддаа хүрээлэн буй орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааны талаарх мэдлэгийг түгээж ажиллана.

4.7. Компани нь хөрс, ус, агаар, биологийн олон янз байдал, байгалийн сэргээгдэх болон сэргээгдэхгүй шавхагдаж буй нөөцийг хадгалан хамгаалж, тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байхаар тогтвортой ашиглах хандлагыг дэмжин ажиллана.

5. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

5.1. Компани нь Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт, соёлын өвийг хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх зорилттой тус тус үйлдүүлэн хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

5.2. Компани нь Монгол Улсын түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх соёлын онцгой өв болох ёс заншил, хэл, бусад өв, түүнчлэн соёл, түүх, археологи, палентологийн түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалах аливаа үйл ажиллагааг дэмжин ажиллана.

5.3. Компани нь хүний эрхийг хүндэтгэж, хөдөлмөрийн стандартыг мөрдөж, иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хариуцлагатай үйл ажиллагаа явуулна.

5.4. Компани нь түүх, соёлын өв, археологи, палеонтологийн олдворуудыг хамгаалах үйл ажиллагааг дэмжих.

6. ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

6.1. Компанид зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлэх,

түүний хэрэгжилтийг хангах зорилгын хүрээнд холбогдох хууль, тогтоомж болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгийг мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

6.2. Компани нь Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид ТҮЗ гэх/ нь үйл ажиллагаанд дараах зарчимийг баримтлана.

6.2.1. ТҮЗ нь БОНЗ-ын бодлого, стратегийг баталж, компанийн урт хугацааны стратегитай нийцлийг ханган, хэрэгжилт болон гүйцэтгэлд стратегийн хяналт тавьж ажиллана.

6.2.2. Компанид зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлэх, түүний хэрэгжилтийг хангах зорилгын хүрээнд холбогдох хууль, тогтоомж, дотоод журмын дагуу мэдээллийг ил тод тайлагнахад анхаарч ажиллана.

6.3. Гүйцэтгэх удирдлага нь БОНЗ бодлогын хэрэгжилтийг хариуцан, компанийн бизнес, дунд хугацаа, санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд БОНЗ асуудлыг тусгаж, гүйцэтгэлийг ТҮЗ-д тогтмол тайлагнана.

6.4. Захирлуудын зөвлөл буюу менежментийн баг нь БОНЗ-ийг компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай уялдуулах, төсөл, худалдан авалт, хүний нөөц, санхүүгийн үйл ажиллагаанд БОНЗ шалгуур оруулах, тайлагналыг бэлтгэж ажиллана.

6.5. Охин компаниуд нь БОНЗ гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт (KPI), эрсдэлийн үнэлгээ болон хэрэгжилтийн мэдээллийг жил бүр группийн түвшинд нэгтгэн тайлагнана.

6.5.1. Компани нь охин компаниудын БОНЗ бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд үнэлгээ хийх, зөвлөмж өгөх, сайжруулалтын төлөвлөгөө батлуулах эрхтэй байна.

6.5.2. Охин компаниуд нь энэхүү бодлогын доод шаардлагыг хангаж ажиллах бөгөөд салбарын онцлог, хууль эрх зүйн шаардлагаас шалтгаалан илүү өндөр стандартыг мөрдөх боломжтой.

6.6. БОНЗ, Олон нийттэй харилцах хэлтсийн нь үйл

ажиллагаанд дараах зарчимийг баримтлана.

6.6.1. БОНЗ, Олон нийттэй харилцах хэлтэс нь компанийн БОНЗ бодлого, стратегийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж, байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах арга хэмжээг нэгтгэн удирдана.

6.6.2. Тус хэлтэс нь БОНЗ-той холбоотой гүйцэтгэлийн үзүүлэлт (KPI) болон мэдээллийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, тайлагналын үнэн зөв, ил тод байдлыг хангана.

6.6.3. Компанийн үйл ажиллагаа, төсөл, худалдан авалт, хүний нөөц, санхүүгийн шийдвэр гаргалтад БОНЗ шаардлагыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэх удирдлагад тайлагнан, ТҮЗ-ийн хяналтад ажиллана.

7. БОНЗ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАГНАЛ

7.1. Компани нь БОНЗ тайлагналыг олон улсын стандартын дагуу бэлтгэж, шаардлагатай тохиолдолд дотоод болон гадаадын хараат бус аудит, баталгаажуулалтад хамруулж болно.

7.2. Компани нь БОНЗ-ын бодлогын хэрэгжилтийг санхүүгийн тайлагналтай уялдуулан жилд нэг удаа үнэлж, ТҮЗ-ийн хуралд тайлагнана.

8. ХЯНАЛТ ХАРИУЦЛАГА

8.1. Энэхүү бодлого нь ТҮЗ-өөр батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

8.2. Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлогыг хэрэгжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бий болгох, тайлагнахад компанийн бүх ажилтнууд чиг үүргийн хүрээнд тогтмол анхаарч хамт олны үнэт зүйл, эрхэм зорилт, ёс зүйн үндсэн зарчим, хэм хэмжээг хатуу баримталж ажиллана.

8.3. Бодлогыг жил бүр хянаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулна.

Материаллаг байдлын үнэлгээ ба арга зүй

Бодь Групп нь 2025 оны Тогтвортой хөгжлийн тайлангийн хүрээнд олон улсын GRI 2021 болон Европын холбооны CSRD аргачлалд суурилсан “Давхар материаллаг байдлын үнэлгээ”-г гүйцэтгэв. Үнэлгээнд дотоод болон гадаад оролцогч талуудыг хамруулж, нийт 14 тэргүүлэх асуудлыг тодорхойлон эрэмбэлсэн.



Нөлөөллийн материаллаг байдал

Бизнесийн үйл ажиллагаанаас нийгэм болон байгаль орчинд үзүүлж буй бодит нөлөөлөл

1. Асуудлын сан бүрдүүлэх

Олон улсын стандарт (GRI, ESRS) болон салбарын онцлогт тулгуурлан суурь асуудлуудыг жагсаах.

3. Давхар үнэлгээ хийх

Нөлөөллийн болон санхүүгийн ач холбогдлын түвшинг тогтоох.



Санхүүгийн материаллаг байдал

БОНЗ хүчин зүйлсээс компанийн санхүүгийн тогтвортой байдал, эрсдэл, боломжид үзүүлэх нөлөөлөл

2. Нөлөөллийг тодорхойлох

Бодит болон боломжит, эерэг болон сөрөг нөлөөллийг үнэлэх.

4. Эрэмбэлэх


Үр дүнг матрицад байршуулж, “ТОП 14” асуудлыг эцэслэх.

Үнэлгээнд дотоод болон гадаад оролцогч талуудыг хамруулж, нийт 14 материаллаг асуудлыг тодорхойлон эрэмбэлэв.

Материаллаг байдал	ESG	Санхүүгийн материаллаг байдал	Нөлөөллийн материаллаг байдал	Стандарт
1. Хөдөлмөрийн аюулгүй байдал	S	Маш өндөр	Маш өндөр	GRI 403
2. Эрчим хүчний аюулгүй байдал, хэмнэлт	E	Маш өндөр	Маш өндөр	GRI 304–306
3. Байгаль орчны нөлөөлөл, нөхөн сэргээлт	E	Өндөр	Маш өндөр	TCFD / GRI 305
4. Компанийн засаглал, ёс зүй, ил тод байдал	G	Маш өндөр	Өндөр	GRI 205
5. Уур амьсгалын өөрчлөлт, CO ₂ ялгарал	E	Өндөр	Маш өндөр	GRI 302
6. Орон нутгийн хөгжил, оролцоо	S	Дунд	Маш өндөр	GRI 413
7. Биологийн олон янз байдал	E	Дунд	Өндөр	GRI 304
8. Хангамжийн сүлжээ, нийлүүлэгчийн хариуцлага	G	Өндөр	Өндөр	GRI 308
9. Хог хаягдлын менежмент	E	Дунд	Өндөр	GRI 306
10. Авилгын эсрэг ёс зүйт байдал	G	Дунд	Өндөр	GRI 205
11. Ажил мэргэжлийн, нийгэм, байгалийн нөлөө	S	Дунд	Дунд	GRI 401
12. Хоол хүнсний аюулгүй байдал (НАССР)	S	Дунд	Дунд	GRI 416
13. Жендерийн тэгш байдал, олон талт байдал	S	Дунд	Дунд	GRI 405
14. Мэдээллийн аюулгүй байдал, нууцлал	G	Өндөр	Өндөр	GRI 418

Нийгэм · Байгальд нөлөөлөл ↑

- 1-3 Хамгийн чухал
- 4-8 Чухал
- 9-14 Хяналтанд
- E-Байгаль орчин
- S-Нийгэм
- G-Засаглал



Оролцогч талуудын оролцоо ба БОНЗ-ын ач холбогдол



Бодь Групп нь оролцогч талуудын хүлээлтэд тулгуурлан БОНЗ-ын материаллаг байдлын үнэлгээг хийдэг.

Бид тогтмол уулзалт, тайлагналаар дамжуулан Группийн хэмжээний дэд бүтэц, стратегийн төслүүдийн нийгэм, байгаль орчны үр нөлөөг нээлттэй мэдээлдэг.

Оролцогч тал	Харилцах сувгууд	БОНЗ-ын тэргүүлэх асуудлууд
<p>Хувьцаа эзэмшигчид ба Хөрөнгө оруулагчид</p> <p>Бид урт хугацааны үнэ цэнийг бүтээж, засаглалын ил тод байдлыг эрхэмлэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> • ТУЗ болон хороодын хурал • 2026 оны KPI/OGSM төлөвлөгөө • Жилийн БОНЗ болон санхүүгийн тайлан • Дотоод аудитын хяналт 	<ul style="list-style-type: none"> • Компаниудын нэгдсэн засаглал ба ёс зүй • Санхүүгийн тогтвортой байдал • Олон улсын ISO стандартын нийцэл • Эрсдэлийн удирдлага
<p>Захиалагч ба Түншүүд</p> <p>Инженерийн шилдэг шийдэл, нийлүүлэлтийн найдвартай сүлжээгээр дамжуулан үнэ цэн бүтээх.</p>	<ul style="list-style-type: none"> • Техникийн зөвлөлдөх уулзалт • Төслийн хэрэгжилтийн явцын тайлан • Бизнес уулзалт, гэрээний хяналт • Үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаа 	<ul style="list-style-type: none"> • Нийлүүлэлтийн сүлжээний хариуцлага (ISO 20400) • Технологийн инноваци ба дижитал шилжилт • Чанарын удирдлага (ISO 9001) • Төслийн хугацаа болон гүйцэтгэл
<p>Ажилтнууд</p> <p>Бид өндөр бүтээмжтэй, ХАБЭА-г дээдэлсэн, хөгжлийг дэмжигч хамт олныг төлөвшүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> • Дотоод мэдээллийн портал • "Bodi Voice" санал гомдлын суваг • Гүйцэтгэлийн удирдлага (KPI) • "Bookaholic" клуб зэрэг сайн дурын ажил 	<ul style="list-style-type: none"> • ХАБЭА (ISO 45001) • Ажилтны сургалт, мэргэжлийн өсөлт • Жендерийн тэгш байдал, олон талт байдал • Ажлын байрны тав тух, соёл
<p>Нийгэм ба Орон нутаг</p> <p>Бүтээн байгуулалтаар дамжуулан амьдрах орчныг сайжруулж, ногоон хөгжлийг дэмжих.</p>	<ul style="list-style-type: none"> • Олон нийтийн хэлэлцүүлэг (Төслийн нөлөөлөл) • Сайн дурын ажил, нийгмийн төслүүд • Хэвлэл мэдээлэл, сошиал сувгууд • БОНЗ-ын нөлөөллийн үнэлгээ 	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчны нөхөн сэргээлт • Эрчим хүчний хараат бус байдлыг дэмжих • Орон нутгийн иргэдийн ажил эрхлэлт
<p>Төрийн байгууллага ба Зохицуулагчид</p> <p>Хууль дээдлэх зарчмыг баримтлан, улс орны хөгжлийн бодлогод хувь нэмэр оруулах.</p>	<ul style="list-style-type: none"> • Албан бичиг, статистик тайлан • Салбарын форум, дугуй ширээний уулзалт • Аудит, хяналт шалгалтын үйл явц 	<ul style="list-style-type: none"> • Хууль тогтоомжийн нийцэл Комплианс) • Татварын ил тод тайлагнал • Авлигын эсрэг бодлого • Ногоон хөгжлийн бодлогын дэмжлэг

Компанийн засаглал, комплаенс ба чанарын удирдлагын тогтолцоо

Манай компани 30 гаруй жилийн ажлын туршлага ба уул уурхай, төмөр зам, ложистикийн дэд бүтцийн томоохон төслүүдэд EPC Ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан туршлагадаа тулгуурлан компанийн засаглал, комплаенс болон тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцоог үе шаттайгаар бэхжүүлэн ажиллаж байна.

Тухайлбал, Тавантолгой–Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төсөл, Тавантолгой–Гашуунсухайт болон Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр замуудын холболтын төмөр замын төсөл, Гашуунсухайт дахь Шилжүүлэн ачих төв, Тавантолгойн нүүрс ачилтын ложистикийн төв зэрэг үндэсний хэмжээний стратегийн ач холбогдол бүхий төслүүдийг хэрэгжүүлсэн туршлага нь эрсдэлийн удирдлага, чанарын хяналт, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс зүй болон засаглалын тогтолцоог байгууллагын хэмжээнд илүү боловсронгуй түвшинд төлөвшүүлэх үндэс суурь болсон. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн тогтоолоор компанийн засаглал, комплаенсын чиглэлээр нийт 9 бодлого, журам баталж, дотоод хяналт, ёс зүй, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх эрх зүйн болон удирдлагын суурийг бүрдүүлсэн. Эдгээр бодлого, журмууд нь байгууллагын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, гэрээний үүрэг, бизнесийн ёс зүйн зарчим болон дотоод хяналтын шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэхэд чиглэж байна. Манай компани нь 2022 оноос ISO 9001 Чанарын менежментийн тогтолцооны стандартыг үйл

ажиллагаандаа нэвтрүүлж, гэрчилгээжүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд тасралтгүй сайжруулалтын зарчмыг байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшүүлэн ажиллаж байна. 2026 оны 3 дугаар сард ISO 9001 стандартын хэрэгжилтийн дундын хяналтын аудитыг олон улсын хөндлөнгийн аудитын байгууллагаар амжилттай хийлгэж, Австралийн Business Systems Certification байгууллагаас дахин баталгаажуулснаар чанарын удирдлагын тогтолцооны үр нөлөө, хэрэгжилтээ олон улсын түвшинд баталгаажуулав. Үүний зэрэгцээ байгууллагын дотоод аудитын тогтолцоог тогтмол хэрэгжүүлж, илэрсэн үл тохирол болон сайжруулалтын боломжуудыг тухай бүрд нь шийдвэрлэн ажиллаж байна. Стандартын хэрэгжилт, тасралтгүй сайжруулалтын үйл ажиллагааг дэмжих зорилгоор газар, хэлтэс, нэгжүүдийн төлөөллөөс бүрдсэн 13 хүний бүрэлдэхүүнтэй Lead Auditor баг ажилладаг.


Тус баг нь дотоод аудит, эрсдэлийн үнэлгээ, стандартын хэрэгжилтийн мониторингийг хэрэгжүүлэхээс гадна байгууллагын засаглал, чанар болон хариуцлагын соёлыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Цаашид компани нь ISO 45001 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоог албан ёсоор нэвтрүүлж, гэрчилгээжүүлэхийн зэрэгцээ тогтвортой хөгжлийн засаглал, комплаенс болон эрсдэлийн удирдлагын тогтолцоог олон улсын сайн туршлага, стандартын шаардлагад нийцүүлэн тасралтгүй хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.



Хавсралт



Бодь Групп - Байгаль орчин, нийгэм, засаглалын стратегийн чиглэл



Чиглэл	I ҮЕ: СТАНДАРТЧИЛАЛ	II ҮЕ: ШИЛЖИЛТ	III ҮЕ: МАНЛАЙЛАЛ
	2025–2027	2028–2030	2031–2033
Зорилтот түвшин	Дотоод засаглалыг бэхжүүлэх	Нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах шинэ технологи ашиглах	Биологийн олон янз байдал ба нийгэмд үзүүлэх эерэг нөлөө
Байгаль орчин	<ul style="list-style-type: none"> • 2025 онд 13,000 гаруй бут, сөөг тарьж, 2.2 га талбайд нөхөн сэргээлт хийх • Бөөрөлжүүтийн усны нөөцийг хамгаалах зорилгоор 5 га хиймэл нуур байгуулах • Агаарын бохирдол, усны хэрэглээ болон эрчим хүчний хэмжилтийг 4 компанид хэрэгжүүлэх • Хог хаягдлын 15%-ийг дахин боловсруулах 	<ul style="list-style-type: none"> • Бөөрөлжүүт цахилгаан станцын 3, 4-р блок (300 МВт) ашиглалтад оруулах • Цахилгаан тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэх • Нүүрстөрөгчийн ялгарлыг 2025 оны түвшнээс 5%-иар бууруулах 	<ul style="list-style-type: none"> • Хог хаягдлын 50%-ийг дахин ашиглах • Ногоон барилгын стандарт нэвтрүүлэх • Уур амьсгалын эрсдэлийн удирдлагын тогтолцоог иж бүрэн нэвтрүүлэх
Нийгэм	<ul style="list-style-type: none"> • “Бодь Академи” үндсэн сургалтын төвийг Судалгаа хөгжүүлэлтийн төвтэй хамтран байгуулах • 2,500 гаруй ажлын байр нэмэгдүүлэх • 65-аас дээш ханган нийлүүлэгчид нийгмийн хариуцлагын үнэлгээ хийх • Үйлдвэрлэлийн ослыг тэг түвшинд хүргэх зорилгоор аюулгүй ажлын орчны стандарт нэвтрүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Ханган нийлүүлэлтэд орон нутгийн оролцоог 20%-д хүргэх • Хүйсийн тэгш байдлын үнэлгээ, шалгуурыг бүх охин компанид хэрэгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Ажилтны сэтгэл ханамжаар бизнес салбартаа тэргүүлэх түвшинд хүрэх • Үндэсний Соёл Амралтын Хүрээлэн ХХК-ийн соёл, түүхийн өвийг хамгаалах хөтөлбөрийг өргөтгөх
Засаглал	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчин, нийгэм засаглалын хороо байгуулах • Хүний нөөцийн удирдлагыг автоматжуулах • Ханган нийлүүлэгчдийн хариуцлагын аудитыг эхлүүлэх • Удирдлагын шийдвэр гаргалтын нээлттэй байдлыг бэхжүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Олон улсын хөрөнгө оруулалтын зэрэглэл тогтоолгох • Ханган нийлүүлэлтийн сүлжээнд иж бүрэн аудит хийх • Охин компаниудын мэдээллийг нэгдсэн системд нэгтгэх • Гадаад аудитын байгуулагатай хамтарч ажиллах 	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн хариуцлагыг бизнесийн үндсэн соёлын салшгүй хэсэг болгох • Бодь Группийн бүх охин компанид нэгдсэн стандарт хэрэгжүүлэх • Уур амьсгалын эрсдэлийн иж бүрэн удирдлагын тогтолцоо бүрдүүлэх

GRI индекс

GRI 2: Ерөнхий мэдээлэл

Стандарт	Мэдээлэл	Тайлбар
GRI 2-1	Байгууллагын мэдээлэл	Бодь Интернэшнл ХХК - 1993.07.06 байгуулагдсан - Монгол Улс
GRI 2-2	Тайлангийн хамрах байгууллагууд	Бодь Интернэшнл ХХК болон 6 охин компани
GRI 2-3	Тайлагналын хугацаа, давтамж	2025 оны 1-12 дугаар сар буюу жилийн тайлан
GRI 2-4	Мэдээллийн дахин тайлагнал	Анхны цогц БОНЗ тайлан тул өмнөх оны суурь үзүүлэлт байхгүй
GRI 2-5	Гадаад баталгаажуулалт	ISO 9001:2015 — Австралийн BSC хөндлөнгийн аудит (2025 оны 3 дугаар сар)
GRI 2-6	Үйл ажиллагааны салбар, нийлүүлэлтийн сүлжээ	Барилга, уул уурхай, эрчим хүч, тээвэр, аялал жуулчлал
GRI 2-7	Ажилтнууд	Нийт 2,400+ ажилтан; 2025 онд 262 шинэ ажлын байр нэмэгдсэн
GRI 2-9	Засаглалын бүтэц	ТҮЗ, дэд хороод, БОНЗ хариуцсан нэгж
GRI 2-22	Тогтвортой хөгжлийн стратегийн мэдэгдэл	Гүйцэтгэх захирал Б.Долгормаагийн зурвас
GRI 2-23	Бодлого, үүргийн мэдэгдэл	ТҮЗ-ийн 2025.11.20-ны тогтоолоор 22 бодлого, журам батлагдсан
GRI 2-25	Сөрөг нөлөөллийг арилгах үйл явц	Оролцогч талуудын харилцааны суваг, Bodi Voice мэдүүлгийн систем
GRI 2-26	Зохисгүй үйлдлийг мэдүүлэх механизм	Bodi Voice суваг; Ёс зүй, Комплайнсын хороо
GRI 2-29	Оролцогч талуудын оролцооны хандлага	5 бүлэг оролцогч тал — харилцах суваг болон тэргүүлэх асуудлуудыг тодорхойлсон
GRI 2-30	Хамтын хэлэлцээр	Ажилтны эрх, цалин, нийгмийн хамгаалал — ХАБЭА стандартыг бүрэн мөрддөг

GRI 3: Материаллаг сэдвүүд

Стандарт	Мэдээлэл	Тайлбар
GRI 3-1	Материаллаг байдлын үнэлгээний арга зүй	GRI 2021 болон CSRD-д суурилсан давхар үнэлгээ — 4 алхамт аргачлал
GRI 3-2	Материаллаг сэдвүүдийн жагсаалт	Нийт 14 материаллаг асуудал тодорхойлж, эрэмбэлсэн
GRI 3-3	Материаллаг сэдвүүдийн менежмент	БОНЗ хариуцсан нэгж болон Бизнес хөгжлийн газрын удирдлага дор хэрэгжиж байна



Сэдвийн дагуух мэдээлэл

БОНЗ	Стандарт	Мэдээлэл	Тайлбар
E	GRI 302-1	Байгууллага дотоодын эрчим хүчний хэрэглээ	Бодь Интернэшнл ХХК: 63.4М кВт.ц; Үндэсний Соёл Амралтын Хүрээлээн ХХК: 1.44М кВт.ц;
E	GRI 302-3	Эрчим хүчний хэмнэлт	Бодь Пропертийз ХХК: 18% дулааны хэмнэлт /өрхийн бүтэн дулаалалгын жишиг төсөл/
E	GRI 303-1	Усны нөөцтэй харилцах	38 худгийн зөвшөөрөл; Жавхлант нуур экосистем; Сэлбэ голын хиймэл нуур (280,000 м³)
E	GRI 303-2	Усны нөлөөллийн менежмент	Бөөрөлжүүт уурхайн шүүрлийн усыг дахин ашиглан хиймэл нуур байгуулсан
E	GRI 303-3	Усны хэрэглээ	Бодь Пропертийз ХХК: 83% бууралт (4,800 м³)
E	GRI 304-1	Хамгаалалттай газрын ойролцоо үйл ажиллагаа	Рэд Рок Холдинг ХХК: Горхи-Тэрэлж байгалийн цогцолборт газар; Хөвсгөл нуурын зүүн эрэг
E	GRI 304-2	Биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөлөл	Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК: Жавхлант нуур - тогоруу, гангар хун зэрэг 5 гаруй зүйлийн ховор шувуу нутагшсан
E	GRI 305-1	Scope 1 хүлэмжийн хийн ялгарал	Рэд Рок Холдинг ХХК: 3,837 тн (-18.4%); Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК: 1.49М тн; Бодь Рэйл: 11,072 тн
E	GRI 305-2	Scope 2 хүлэмжийн хийн ялгарал	Scope 1+2 нийт ялгарлыг тайлагнасан
E	GRI 305-5	Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах	100 Зуун Мод: жилд 230 тн CO ₂ шингээлт; 2030 он: 5% бууруулах зорилт
E	GRI 306-1	Хог хаягдал үүсгэх, нөлөөлөл	Нийт 4,271.5 тн (энгийн + барилгын); 16.1 тн аюултай хаягдал
E	GRI 306-3	Үүссэн хог хаягдлын хэмжээ	Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК: 18,360 тн үнс шаарга бетоны үйлдвэрт; 1,065,650 тн төмөр боловсруулах үйлдвэрт
E	GRI 306-4	Хог хаягдлыг дахин ашиглах	3R зарчим; 175.1 тн бетоныг орон нутгийн тохижилтод дахин ашигласан
E	GRI 306-5	Хог хаягдлыг устгах	16.1 тн аюултай хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудад шилжүүлсэн
S	GRI 401-1	Шинэ ажилтан авах, ажилтан гарах	2025 онд 262 шинэ ажлын байр; нийт 5,400+ ажилтан

БОНЗ	Стандарт	Мэдээлэл	Тайлбар
S	GRI 401-2	Ажилтнуудад олгох тэтгэмж	4В хөтөлбөр
S	GRI 403-1	ХАБЭА-н удирдлагын тогтолцоо	ISO 45001 нэвтрүүлэх төлөвлөгөөтэй; Тэг осол гэмтэл зорилт
S	GRI 403-2	Аюулыг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх	Жилд 1,500 удаагийн хяналт шалгалт хийгдсэн
S	GRI 403-4	ХАБЭА-н ажилтны оролцоо, зөвлөлдөх	ХАБЭА сургалт: 2,486 ажилтан, 5,015 хүн-цаг
S	GRI 403-9	Ажилтай холбоотой гэмтэл	2.5 сая хүн-цаг осолгүй ажилласан (Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК)
S	GRI 404-1	Ажилтан тутамд ногдох сургалтын дундаж цаг	72,400 нийт сургалтын цаг; нэг ажилтанд 13.4 цаг; 24 мэргэжлийн тэтгэлэг
S	GRI 404-2	Ажилтны ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөр	Bodi Academy: PMP®, Future Leaders менторшип хөтөлбөр
S	GRI 405-1	Удирдлага болон ажилтнуудын олон янз байдал	Жендэрийн тэгш байдал 50%; Рэд Рок: 63.2% эмэгтэй ажилтан
S	GRI 413-1	Орон нутгийн иргэдтэй хамтарсан үйл ажиллагаа	3 суманд жилийн хамтын ажиллагааны гэрээ; Ахмад настанд нүүрс олгох; Мэргэжлийн чиг баримжааны өдөрлөг
S	GRI 413-2	Орон нутгийн иргэдэд ихээхэн нөлөөлсөн үйл ажиллагаа	Mind Free: 5,000+ сурагч хамрагдсан; Орон нутгийн ргэдийг ажлын байраар хангах, оюутнуудын тэтгэлэг олгох, ЕБС-н сурагчдад мэргэжил сонгох зөвөлгөө
S	GRI 416-1	Бүтээгдэхүүн, үйлчилгээний аюулгүй байдлын үнэлгээ	НАССР – Рэд Рок Холдинг ХХК; ISO 9001:2015 чанарын менежмент
G	GRI 205-1	Авилгын эрсдэлд өртсөн үйл ажиллагаа	Ёс зүй, Комплайнсын хороо; 9 бодлого, журам батлагдсан
G	GRI 205-2	Авилгын эсрэг бодлогын сургалт, мэдээлэл	Шинэ ажилтан бүрд ёс зүйн сургалт заавал хамруулдаг
G	GRI 205-3	Баталгаажсан авилгын тохиолдол	Тайлагналын хугацаанд баталгаажсан тохиолдол гараагүй
G	GRI 308-1	Байгаль орчны шалгуураар үнэлэгдсэн нийлүүлэгчид	65 гаруй нийлүүлэгч; 78% дотоодын; Ногоон худалдан авалтын бодлого төлөвлөгдсөн
G	GRI 418-1	Хувийн мэдээллийн хамгааллын зөрчил	Тайлагналын хугацаанд баталгаажсан зөрчил гараагүй



Бодит Ажиглалтын Төлөө

+976-11315144

www.bodigroup.mn

info@bodigroup.mn

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Чингисийн Өргөн Чөлөө, Парк Плейс оффис, 7 давхарт